

НИЙГМИЙН СОНИН САЙХАН

☉ “Баригдсан нь л бид болохоос амьгүй ураг гадаа хаядаг эмнэлэг зөндөө л байгаа” ➔ 3

ЦАГ ҮЕ

☉ Дарханы замд автомашинаа эвдсэн иргэд хуулийн байгууллагад хандаж болно ➔ 5

НИЙГЭМ

☉ Цахилгаан машиныг дэмжих бодлогоо татвараар баллах нь зөв үү ➔ 7

ZGM DAILY

☉ FULL ENGLISH PAGE INSIDE ➔ 20-21

# ЗАСГИЙН ГАЗРЫН МЭДЭЭ



2019.11.15, БААСАН~№201 (1253)

~ МОНГОЛ ХҮН БҮР БАЯЖИГТУН ~

₮1000, 24 НҮҮР

АЛТ	ЗЭС	ТӨМРИЙН ХҮДЭР	НЕФТЬ	ЧИНГИС БОНД	ХУРАЛДАЙ БОНД	ГЭРЭГЭ БОНД	САМУРАЙ БОНД	АМ.ДОЛЛАР	ЮАНЬ	РУБЛЬ	ВОН
1,469.00 5.70%	5,869.00 0.16	640.00 0.00%	56.87 0.65%	109.68 0.13%	113.42 0.12%	101.80 0.12%	103.62 0.60%	2703.09	385.05	42.10	2.31

## Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг МАН 100 хувийн саналаар батлав

Ардчилсан нам хулхидуулж, Ардын нам “хүчиндэв”



Гэрэл зургийг С.Батсайхан

П.Батбөх, ЗГМ сонин

Монгол Улсын түүхэнд тэмдэглэгдэх том үйл явдал өчигдөр тохиов. Хаврын чуулганы төгсгөлд УИХ-ын 62 гишүүний санаачилгаар өргөн барьсан Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуу-

лийн төслийн гуравдугаар хэлэлцүүлгийг хийж баталсан нь энэ удаагийн парламентын хамгийн том амжилт болов. Гуравдугаар хэлэлцүүлгийн гол зорилго АН-аас дэвшүүлсэн гурван саналыг хэлэлцэх, хоёрдугаар хэлэлцүүлгээр баталсан 10 гаруй заалтын эцсийн найруулгыг хийж эцэслэн батлах

байв. Үдээс өмнө парламент Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих журмын тухай хуулийн төслийг хэлэлцсэн юм. Энэ хуулийн төслийг гуравдугаар хэлэлцүүлгийн өмнө хэлэлцэхийг зарим гишүүн буруу гэж үзсэн. АН-ын зөвлөлийн дарга

Д.Эрдэнэбат дагаж мөрдөх журмыг хэлэлцэхээс өмнө “Ямар заалт 57 гишүүний босго давахыг мэдээгүй байж нийцүүлэх журмаа батлах гэж байгаа нь алдаатай” гэж Үндсэн хуулийн гуравдугаар хэлэлцүүлгийг түрүүнд нь хийх горимын санал гаргасан боловч МАН-ын гишүүд дэмжээгүй юм. ➔ 5

☉ Үзэсгэлэнт У.Лаура ➔ 9

Хуульч мэргэжилтэй ч моделиор ажиллаж байгаа түүний алсын зорилго нь улс, эх орондоо хийсэн зүйл, хэлэх үгтэй нэгэн болох гэнэ.



☉ “Мишлений одтой Монголын хамгийн анхны тогооч болохыг хүсдэг” ➔ 10, 11

Монголын анхны Мишлений одтой тогооч болохыг хүсдэг. Энэ бол шилдэг ахлах тогооч нарт олгодог дэлхийн хамгийн нэр хүндтэй шагнал. Тамирчнаар ярих юм бол олимп гэсэн үг.

☉ Бүтээн байгуулалтаар “бялуурах” 2020 оны төсвийн зарлагатай танилц ➔ 16



Өр зээлийн дарамт эдийн засагт өндийх сэхээ өгөхгүй нь. Бүтээн байгуулалтаас илүү олон улсад төлөх өндөр дүнтэй бондуудын эргэн төлөх хугацаа хамар дор ирлээ.

Өнөөдөр	Маргааш
-4°C ☀	-9°C ☀
-16°C 🌙	-13°C 🌙



### Спортынхон бэлгийн дарамтын эсрэг дуу хоолойгоо нэгтгэж эхэллээ

Спортын салбар дахь бэлгийн дарамт, хүчирхийлэл урт хугацаанд байсан зүйл. Өмнө нь энэ талаар хэд хэдэн гомдол гарч байсан. ➔ 3

#17 \$52.2 тэрбум

Майкл Блумберг, Bloomberg LP-ийн ТУЗ-ийн дарга, АНУ-ын бизнесмэн, улс төрч

Бизнес эхлүүлээд л баян болчихдог юм биш. Дэлхий ертөнцийг өөрөөр харж, бусдад саад бэрхшээл, эрсдэл болж буй зүйлсийг боломж болгож байж жинхэнэ энтрепрёнер болно.





## УЛС ТӨР

⊖ Дарханы замд автомашинаа эвдсэн иргэд хуулийн байгууллагад хандаж болно

-Ер нь амжуулах гэж л үзнэ дээ. Бид энэ өвөл хүн, хүч, техник тоног төхөөрөмжөө нэмэх талаар сайн бэлтгэж, өдөр бүрийн нарийвчилсан график гаргаж ажиллана гэж төлөвлөж байна.



→ 5

← 1

Улмаар Д.Эрдэнэбат нарын гаргасан УИХ-ын сонгуулийн холимог тогтолцоог 2020 оноос хэрэгжүүлэх заалтыг дэмжих боломжгүй гэж үзэн, Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих журмын тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг баталж, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүлсэн юм.

Дараа нь УИХ-ын гишүүд гуравдугаар хэлэлцүүлэгт шилжсэн. Эхэнд нь зөвшилцлийн хүрээнд АН-аас дэвшүүлсэн гурван саналыг хэлэлцсэн бөгөөд Ерөнхий сайдад танхимаа бүрдүүлэх эрх олгох заалтын талаар хэлэлцсэн гишүүдийн дийлэнх олонхоор дэмжсэн ч Ерөнхийлөгчийг парламентаас сонгох, УИХ-ын сонгуулийг холимог тогтолцоогоор явуулах хоёр санал 57 гишүүний босго давж чадсангүй. Уг нь



Гэрэл зургийг С.Батсайхан

## Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг МАН 100 хувийн саналаар батлав

Ардчилсан нам хулхидуулж, Ардын нам “хүчиндэв”

сонгуулийг холимог тогтолцоог Үндсэн хуульд тусгах саналыг МАН-ын бүлэг болон Төрийн байгуулалтын байнгын хороо дэмжсэн шийдвэр гаргасан ч гуравдугаар хэлэлцүүлгийн явцад эрх баригч гишүүд байр сууриасаа буцав. Энэ нь АН-ын хувьд мэхлүүлсэн явдал болсон бөгөөд АН-ын зөвлөлийн дарга ч ийм байдал гаргасан эрх баригчдад гомдож байгаагаа илэрхийлсэн. Тэрбээр “Үндсэн хуулийг өөрчлөхийн төлөө АН хичээсэн. Өнгөрсөн хугацаанд Үндсэн хуульд орох бүхий л санал дээр хамтарч ажиллан та бүхэнд итгэж найдаж байсан. Харамсалтай нь АН-аас гаргасан зарчмын гурван саналын хоёрыг нь дэмжсэнгүй. Зөвшилцлийн үр дүн гарсангүй. Энэ удаагийн Үндсэн хуулийн өөрчлөлтийг ийм доголлон байдлаар баталж болохгүй. Тиймээс энэ мөчөөс эхлэн АН-ын зөвлөл, зөвшилцөл болон гуравдугаар хэлэлцүүлгээс гарч байгаагаа албан ёсоор мэдэгдье” гэсэн юм. Харин АН-ын гишүүн Б.Пүрэвдорж

“Үндсэн хуулийг батлах ажлыг та нар үнэхээр гурилдаж байна. Унасан саналаа хурууны хээ унших төхөөрөмжид чихээд босгож баталж байна. Энэ хурууны хээгээр санал хураах төхөөрөмж зүгээр ажиллаж байгааг АН-ын жигүүрт суусан гишүүд нэг ч удаа тийм асуудал гараагүйгээс харж болно. Өнөөдөр нэр хүнд нь унасан УИХ-аар Үндсэн хуулийг батлуулж болохгүй гэж ярьсаар л байгаа. Өнөөдөр Үндсэн хуульд орж байгаа нэмэлт өөрчлөлт чинь Ховд аймгийн захын суманд байгаа иргэний амьдралд нөлөөлөхгүй. Та нарын өнөөдөр тогтоосон сонгуулийн хэлбэр, тоглоомын дүрмээр чинь 2020 оны сонгуулиар ард түмэнтэйгээ хамт хариугаа өгнө гэдгийг хэлье” хэмээн гомдлын үг чулуудаад гарч одов.

АН-ын зөвлөлийг ийн хэлэлцүүлгээс гарснаа мэдэгдсэний дараа МАХН-ын гишүүн О.Баасанхүү “Үндсэн хуульд намын үүргийг “улсын хэмжээнд бодлого хэрэгжүүлж ажиллана” гэсэн заалт орлоо. Уг нь намыг Үндсэн хуульд

болон хөгжлийн бодлогод нийцсэн үйл ажиллагаа явуулна гэж тусгаж болох байсан. Би ийм санал гаргасан ч хүлээж авсангүй. Тиймээс би ч бас гуравдугаар хэлэлцүүлгээс гарч байгаагаа мэдэгдэж байна” гэв. Мөн тэрбээр үгийнхээ төгсгөлд “АН энэ удаа молигодууллаа. Хамгийн харамсалтай нь анхнаасаа МАН-д хулхидуулна даа гэж АН-д хэлж байсан ч үгэнд ороогүй” хэмээн эрх баригчдыг “хатгачихаад” чуулганы танхимаас гарсан юм.

Үүний дараа УИХ-ын дарга Үндсэн хуулийн өөрчлөлтийн хоёрдугаар хэлэлцүүлгээр баталсан заалт болон зарчмын зөрүүтэй саналаар санал хурааж, гишүүд 57-гоос дээш санал өгснөөр гуравдугаар хэлэлцүүлгийг дуусгасан юм. Ингэснээр АН Үндсэн хууль батлах үйл явцад цэвэр хулхидуулж МАН гишүүдийн олонхоор нэмэлт өөрчлөлтийг “хүчиндэв”.

Гуравдугаар хэлэлцүүлгийн төгсгөлд спикер Г.Занданшатар энэ удаагийн өөрчлөлтөөр Үндсэн хуульд тусгаж буй зүйл, заалтыг

цэг, таслал алгасалгүй уншиж танилцуулсан. **Тэдгээрээс онцлох заалтуудыг дурдвал, Ерөнхий сайдын нэрийг өргөн барьснаас хойш 30 хоногийн дотор УИХ баталж чадахгүй бол Ерөнхийлөгч парламентыг тараах, хариуцлага алдсан шүүгчийг огцруулах болон сахилгын шийтгэл оногдуулах сахилгын хороог байгуулах, УИХ-ын гишүүн өргөсөн тангаргаасаа няцаж, Үндсэн хууль зөрчсөн бол эгүүлэн татах, УИХ-ын сонгууль явуулахаас нэг жилийн өмнөөс холбогдох хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахыг хориглох Ерөнхий сайдад танхимаа өөрөө бүрдүүлэх, сайд нараа огцруулах эрх олгох, Засгийн газрын гишүүдийн дөрөв нь парламентын гишүүн байж болохыг зөвшөөрсөн заалт орлоо.** Харин Ерөнхий сайдыг огцруулах асуудлыг УИХ-ын гишүүдийн дөрөвний нэг санал гаргасан тохиолдолд парламентаар гурав хоногийн дотор хэлэлцэж 10 хоногийн дотор шийдвэр гаргаж байхаар болов. Мөн Ерөнхийлөгчид 50 нас хүрсэн

сүүлийн таван жил эх орондоо оршин суусан иргэнийг нэг удаад зургаан жилээр сонгоно.

Үндсэн хуульд орсон эдгээр өөрчлөлтийг 2020 оны тавдугаар сарын 25-ны өдрийн 12:00 цагаас улс орон даяар мөрдөхийг төгсгөлд нь тусгажээ.

Гишүүд санал өгсний дараа УИХ-ын дарга Үндсэн хуульд оруулах нэмэлт өөрчлөлтийн төслийг боловсруулсан, гурван шатны хэлэлцүүлэгт бэлтгэсэн, зөвшилцөл хэлэлцүүлэгт оролцсон, саналаа өгсөн бүхий л хүмүүст талархсанаа илэрхийлж, чуулганы танхим алга ташилтаар мялаав. Үндсэн хуулийн шинэ өөрчлөлтийг баталсныг тохиолдуулан Төрийн дуулал эгшиглэж гишүүд алга ташин баяр хүргэлээ. Хуралдааны төгсгөлд УИХ-ын дарга нэмэлт, өөрчлөлт оруулсан Үндсэн хуулийг Ерөнхий сайд У.Хүрэлсүхэд гардуулснаар УИХ чуулганы нэгдсэн хуралдаан болон байнгын хороогоор 36 удаа, 105 цаг хэлэлцэж, дөрвөн сарын хөдөлмөр зарцуулсан түүхэн үйл явдлыг ард гарснаа зарлав. ■



2.5.11. “Эрдэнэт-Овоот”, “Богд хаан” төмөр замыг барих ажлыг эхлүүлж, дамжин өнгөрөх тээврийг хөгжүүлнэ.



Эрх баригч намын 2016 оны сонгуулийн мөрийн хөтөлбөрөөс...



мэдээ, мэдээлэл

## Монголын миссийн танилцуулгыг 24 цагийн дотор 9300 гаруй хүн үзжээ

Б.Сэлэнгэ, ЗГМ сонин

“Дэлхийн мисс 2019” тэмцээнд эх орноо төлөөлөн оролцох М.Цэвэлмаагийн видео танилцуулга хоёр хоногийн өмнө цацагдаж эхэлсэн. М.Цэвэлмаагийн танилцуулга видео YouTube сувагт албан ёсоор байршсанаас хойш эхний 24 цагийн дотор 9300 гаруй хүн үзэж сонирхсон байна.



ACE STUDIO-ийн хийсэн тус видеонд М.Цэвэлмаа нүүдлийн соёл, ёс заншил, байгалийн тогтоц, гоо үзэсгэлэн, монгол ахуйгаа танилцуулсан бөгөөд тэрбээр энэхүү танилцуулгын үзэлт, түгээлтээрээ “Дэлхийн мисс” тэмцээний MULTIMEDIA номинацид өрсөлдөх аж. Видеог үзсэн хүмүүсийн дийлэнх нь Монгол орны байгалийг харуулсан зураглал нь сайн болсныг хүлээн зөвшөөрсөн бол мисс М.Цэвэлмааг үзэсгэлэнтэй, бас ухаантай охин гэж магтжээ.

# Спортынхон бэлгийн дарамтын эсрэг дуу хоолойгоо нэгтгэж эхэллээ

Хүчирхийллээс хамгаалахад чиглэсэн хууль, эрх зүйн орчныг бүрдүүлэх нь чухал байна

Г.Баярсайхан, ЗГМ сонин

**М**онголын спортод бэлгийн дарамт амьбөхтэй оршсоор байгаа нь “Эмэгтэй удирдагч” сангийн хийсэн судалгаагаар ил болсон. Манай сонин энэхүү бусармаг зүйлийн эсрэг хамтдаа тэмцэж, дуу хоолойгоо нэгтгэхийг спортынхонд уриалж буй. Тэгвэл Монголын буудлагын холбоо бидний уриалгыг дэмжиж, хамтран ажиллахаа илэрхийллээ. Тус холбооны Удирдах зөвлөлийн гишүүн П.Тунгалагтай уулзаж, энэ талаар ярилцсан юм.

**-Монголын буудлагын холбоо манай сонины уриалгыг хамгийн түрүүнд дэмжсэнд талархаж байна. Танай холбоо үүний хүрээнд ямар ажил хийхээр төлөвлөж байна вэ?**

-Спортын салбар дахь бэлгийн дарамт, хүчирхийлэл урт хугацаанд байсан зүйл. Өмнө нь энэ талаар хэд хэдэн гомдол гарч байсан. Харамсалтай нь тухайн үед бид нэгдэж, дуу хоолойгоо хүчтэй хүргэж чадаагүй учраас тэгсгээд намжсан. Харин одоо спортын салбарт хичээллэж байгаа тамирчид, хүүхдүүдийн орчныг аюулгүй болгох тал дээр манай сэтгүүлчид идэвх санаачилга гаргаж, бусдыг уриалан дуудаж байгааг Монголын буудлагын холбоо, Удирдах зөвлөлийн гишүүд дэмжиж байна. Энэ асуудалтай холбоотойгоор бид уриалга гаргахаар төлөвлөсөн. Мөн цаашид энэхүү ёс зүйгүй үйлдлийг гаргахгүйн тулд ямар арга хэмжээ авч, хэрхэн хамтарч ажиллах вэ гэдэг хамгийн чухал.

**-Спорт дахь бэлгийн дарамтын эсрэг тэмцэхийн тулд бид**

**юун дээр анхаарах ёстой вэ?**

-Бэлгийн дарамт бол маш эмзэг асуудал учраас тун болгоомжтой хандахгүй бол асуудал буруугаар эргэх эрсдэл бий. Ялангуяа олимпын наадам эхлэх дөхсөн энэ үед бид асуудалд нухацтай хандах нь хамгийн чухал. Спортод бэлгийн дарамт байгаа нь судалгаагаар нотлогдчихлоо. Тэгвэл үүнийг байхгүй болгохын тулд юуны өмнө тамирчид, дасгалжуулагч, энэ салбарт ажиллаж байгаа бүх хүнд хамаарах ёс зүйн журмаа шинэчлэх шаардлагатай. Мөн хүчирхийллээс хамгаалахад чиглэсэн хууль, эрх зүйн орчныг бүрдүүлж, тамирчин, дасгалжуулагч нарт хуулийн мэдлэг олгох сургалтуудыг удаа дараа зохион байгуулах ёстой. Үүнээс гадна хамтарсан ажлын хэсэг байгуулж, хүчирхийлэлд өртсөн тамирчдад эмнэлэг, сэтгэл зүйн тусламж үзүүлэх тал дээр онцгой анхаармаар байна.

**СПОРТЫН САЛБАР ДАХЬ БЭЛГИЙН ДАРАМТ ӨМНӨ НЬ ГАРЧ БАЙСАН. ХАРАМСАЛТАЙ НЬ ТУХАЙН ҮЕД БИД НЭГДЭЖ, ДУУ ХООЛОЙГОО ХҮЧТЭЙ ХҮРГЭЖ ЧАДААГҮЙ УЧРААС ТЭГСГЭЭД НАМЖСАН.**

**-Судалгаанаас харж байхад өндөр зэрэглэлд хүрсэн, шигшээ багийн тамирчид бэлгийн дарамтад өртөх магадлал илүү байдаг юм байна. Тухайн тамирчныг олимп, ДАШТ зэрэг том тэмцээнд явуулахгүй гэх зэргээр дарамталдаг болох нь**



Гэрэл зургийг Ж.Гэрэлчулуун

**тогтоогдсон. Энэ бас анхаарах ёстой чухал асуудал байх.**

-Энэ судалгааг шигшээ багийн түвшинд хийсэн байна лээ. Үүний дараа бусад спорт холбоо хүсэлт гаргаж, өөрсдийн бэлтгэл хийж буй орчноо судлуулбал арай өөр үр дүн гарах байх. Гэхдээ бид ийм тохиолдол шинээр гараасай гэж хүсэж байгаа юм биш. Харин гаргахгүйн төлөө ажиллах хэрэгтэй.

Одоо тамирчдын гэр бүл, эцэг эх, хамаатан садан, найз нөхөд нь тамирчдаа анхааралдаа авч, сайн ярилцаж, ийм асуудал байдаг

бол холбогдох байгууллагад мэдээлэх нь чухал байна. Танай сонины зүгээс спортын салбар дахь бэлгийн дарамтын эсрэг хамтраад тэмцье гэсэн уриалга гаргасанд үнэхээр баяртай байна. Одоо спортын удирдах дээд байгууллагууд буюу салбарын яам, БТСГ, бусад спорт холбоо, МҮОХ бүгд нэгдэж, холбогдох журмуудыг гаргаж, таниулан сурталчлах ажил хийгээсэй гэж хүсэж байна. Үүнийг бодитой ажил хэрэг болгохын тулд холбоод бие биенийгээ дэмжиж, хамтран ажиллахыг уриалья. ■

## “Баригдсан нь л бид болохоос амьгүй ураг гадаа хаядаг эмнэлэг зөндөө л байгаа”

Торонд хийн хаясан байсан хоёр ураг 35 орчим долоо хоногтой байжээ

Б.Энхжин, ЗГМ сонин

**Одоогоор эмнэлгийн хоёр эмчийг баривчилж, мэдүүлэг авч байгаа юм. Нэг нь үр хөндөлтийг гардан хийсэн бол нөгөөх нь ургийг гудамжинд гаргаж хаясан аж.**

Монголд өдөр бүр л ямар нэг сенсаацтай мэдээ түгэж, иргэд ч үүнд нь дасах шинжтэй болжээ. Гэхдээ өчигдөр цацагдсан ээлжит

бараан мэдээ олныг үнэхээр хирдхийлжэв. Хувийн эмнэлгүүд жирэмсэн бүсгүйчүүдэд үр хөндөлт хийсний дараа амьгүй ургийг гадаа шууд хаядаг болох нь цагдаагийн байгууллагын хийсэн шалгалтаар тодорхой боллоо. Тодруулбал, энэ сарын 5-ны өдөр СХД-ийн нэгэн иргэн торон дотор хийгээд орхисон хоёр ширхэг амьгүй ургийг олж, цагдаагийн байгууллагад дуудлага өгсөн байна. Цагдаагийнхан үүний мөрөөр мөрдөн шалгах ажиллагаа

явуулахад тус дүүрэгт үйл ажиллагаа явуулдаг нэгэн хувийн эмнэлгийнхэн хүний санаанд багтамгүй дээрх хэргийг үйлдсэн нь илэрсэн юм. Энэ талаар ЦЕГ-ын Хэвлэл мэдээллийн төвийн дарга Б.Баатархүү “СХД-ийн цагдаагийн 1-р хэлтсээс шалгалт явуулахад тус дүүрэгт байрлах нэгэн хувийн эмнэлэг эмэгтэйчүүдэд аборт хийгээд, ургийг гудамж талбай, олон нийтийн газар хаядаг байж болзошгүй хэргийг илрүүлж,

мөрдөн шалгах ажиллагаа явуулж байна. Холбогдох хууль тогтоомжийн дагуу энэ хэрэгт эрүү үүсгэх болно. Шалгалт үргэлжилж байгаа болохоор илүү дэлгэрэнгүй мэдээлэл өгөх боломжгүй. Надад ирсэн мэдээллээр энэ хэрэг анхных биш, өмнө нь хэд хэдэн удаа давтагдсан байж болзошгүй байна” хэмээн ярилаа.

Эх сурвалжийн мэдээлж буйгаар аборт хийсэн ургийг гудамжинд хаясан эмнэлэг тус дүүргийн

19 дүгээр хороонд байрладаг аж. Одоогоор эмнэлгийн хоёр эмчийг баривчилж, мэдүүлэг авч байгаа юм. Нэг нь үр хөндөлтийг гардан хийсэн бол нөгөөх нь ургийг гудамжинд гаргаж хаяжээ. Тэд цагдаа нарт мэдүүлэг өгөхдөө “Баригдсан нь л бид болохоос угаасаа ийм зүйл хаа сайгүй л байгаа шүү дээ” хэмээн хэнэг ч үгүй ярьж байсан гэнэ. Торонд хийн хаясан байсан хоёр ураг 35 орчим долоо хоногтой байжээ. ■

# АВ, ХАДГАЛ, ХУДАЛД

## БЕЛИНДА ЧАН

“James Beard” сангийн шагналт дарсны зөвлөх мэргэжилтэн



## МОТИШНИБЕРГ

Урлагийн зах зээлийн цогц мэдээллийн вэбсайт “Mutual Art”-ийн ТУЗ-ийн дарга



## КЕН ГРОСС

“Peterson” автомашины музейн захирал асан, зохиолч



## 2014 ОНЫ “CORISON CABERNET SAUVIGNON”, НАПА

Уг дарсны тансаг амтыг хонины шарсан гуятай хослуулан мэдэрч болно. Эсвэл зоориндоо 10 жил тэвчээртэй хадгалж ч болох юм. Одоогоор 85 ам.долларын үнэтэй байгаа тул нөөцлөөд ав.



## 2017 ОНЫ “LULI CHARDONNAY”, САНТА-ЛУЧИЯ ХАЙЛЕНДС

Пизонигийн гэр бүл дэлхийд тэргүүлэгч пино-нуар сортын дарс үйлдвэрлэдэг ба Калифорнийн шардоне дарсных нь амт, чанар 20 ам.долларын үнээ хол давжээ. Энэ дарсыг хадгалах тусам чанарждаг.



## 1995 ОНЫ “CHATEAU CALON-SEGUR”, СЕНТ-ЭСТЕФ

Нэгэн үе алдаршиж байсан энэ дарс 20 гаруй жил хадгалагдсаны эцэст амт чанараа гайхуулж байна. Дуудлага худалдаанд оролцвол 130 ам.долларын үнэд хүрнэ.



## KAWS

Энэ жилийн дуудлага худалдааны борлуулалтын 70 орчим хувийг поп арт урсгалаар туурвидаг гудамжны уран бүтээлчийн бүтээл эзэлжээ. Нэг сая ам.доллараас доош үнээр худалдан авч чадвал ашгаа хурдан өгөх “хямд” KAWS-той болсонд тооц.



## ЖОАН МИТЧЕЛЛ

Америкийн хийсвэр экспрессионист зураач Митчелл өнгөрсөн жил бүтээлээ 17 сая ам.доллараар худалдаж, авьяас билгээ батлан харуулсан юм. Тавдугаар сард тэрбээр бүтээлээ “Christie's” төвийн таамаглаж байснаас хоёр дахин өндөр үнээр худалджээ.



## БЕРНАР БЮФФЕ

Францын экспрессионист зураач Бюффегийн уран бүтээлийн ханш 2010 оноос хойш тогтмол өссөн ч өдгөө дунджаар 52,000 орчим ам.долларт хүрэн тогтворжжээ. Тиймээс өөрт байгаагаа худалдах цаг болсон.



## DATSUN 240Z

Японы спорт машинууд, тэр дундаа 1970-1973 оны “Datsun 240Z” загварынх нь үнэ өсөж байна. Элэгдэж зэвэрдэггүй, хүчирхэг төмөр хүлэгт 60,000 ам.доллар орчмыг төлнө гэж тооцоод хурдхан өөрийн болгоорой.



## JAGUAR XK120

Хуучны загварын задгай дээвэртэй “Jaguar” 500,000 ам.долларын үнэд хүрч байна. Харин дөрвөн хүний суудалтай, битүү дээвэртэй спорт загварыг нь 120,000 ам.доллараар худалдан авах боломж байна.



## 2005-2006 ОНЫ “FORD GT”

“Ford”-ийн энэхүү хүчирхэг загвар ойролцоогоор 4,000 ширхэг үйлдвэрлэгдсэн. Өдгөө анхны үнэ нь хоёр дахин өсөж 300,000 орчим ам.долларт хүрсэн ч зах зээл ханаж, ханш унах магадлалтай.

## [ЗГМ СӨНИН]

“Засгийн газрын мэдээ” сонин нь ардчилсан, шударга ёс, хүний эрхийг дээдэлж, чөлөөт сэтгүүл зүйн хэм хэмжээг бүрнээ сахин, олон ургальч үзлийг илэрхийлэх мэдээллийн индэр байж, нийт Монгол үндэстний ойлголцол, эв нэгдлийг бэхжүүлэхийг эрхэм зорилго болгоно.

ТУЗ-ийн дарга  
**Эрдэнэбаатарын ДОЛГИОН**  
Ерөнхий эрхлэгч  
**Баатарын Дуламхорлоо**  
Зөвлөх  
**Шатарбалын Даваадорж**  
Орлогч эрхлэгч  
**Лхагважавын Сугармаа**  
Утас: 99903584

### РЕДАКЦ

Улс төр, нийгэм, эрэн сурвалжлах мэдээллийн алба  
Эдитор Б.Энхжаргал  
Утас: 99901621

Цахим контент, бүтээлч үйлдвэрлэлийн алба  
Эдитор Г.Баярсайхан  
Утас: 99903574

Эдийн засаг, уул уурхайн мэдээллийн алба

### ЗАР СУРТАЛЧИЛГАА

Утас: 99903581  
99903578  
99907843

### ЦАХИМ ХУВИЛБАР

zgm.mn  
ubinfo.mn

### ХАЯГ

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,  
I хороо, Энхтайваны өргөн чөлөө,  
“Блю Скай тауэр” 407 тоот  
Улсын бүртгэлийн дугаар. 1024  
Утас: 70103131,  
Факс: 70106065

### ДУГААРЫН УДИРДАГЧ

**Б.Энхжаргал**

### ТОДРУУЛГА & ЗАЛРУУЛГА

Уншигч та манай сонины мэдээ, нийтлэл, сурвалжилгатай холбоотой тодруулж, залруулах шаардлагатай санал, хүсэлт байвал  
» [INFO@ZASAG.CO](mailto:INFO@ZASAG.CO)  
Утас: 99903584 хаягаар бидэнтэй холбогдоно уу.



## ЦАГ ҮЕ

ЗГМ: ТОДРУУЛГА

# Дарханы замд автомашинаа эвдсэн иргэд хуулийн байгууллагад хандаж болно

Ирэх жил Улаанбаатар-Дархан чиглэлийн автозамыг хэсэгчлэн хааж хатуу хучилтыг хийнэ



✎ Б.Гарьд, ЗГМ сонин

Улаанбаатар-Дархан чиглэлийн автозам хугацаандаа ашиглалтад ороогүйгээс тус замаар зорчдог аймгийн иргэд бухимдалтай байгаа. Мөн Дархан-Уул, Орхон, Сэлэнгэ аймгаас сонгогдсон УИХ-ын зарим гишүүн Дарханы зам хугацаандаа ашиглалтад ороогүй шалтгааныг тодруулахаар ЗТХ-ийн сайдад асуулга тавиад буй юм. Асуулгатай холбогдуулан сайд Б.Энх-Амгалангаас зарим зүйлийг тодрууллаа.

**-Дарханы зам хугацаандаа ашиглалтад ороогүй асуудлаар УИХ-ын гишүүд асуулга тавьж байгаа. Энэ талаар юу хэлэх вэ?**

-Тийм. Дарханы замын тухайд УИХ-ын гишүүдийн тавьсан асуулгад хариулт өгөхөөр бэлтгэж байна. Хариулт нь маш тодорхой байгаа. Дарханы замыг барьж

ашиглалтад оруулах үндсэн гэрээ нь 2020 оны зургаадугаар сард дуусна. Гэрээний эхний үе шат энэ сард дуусах байсан. Түүгээр хөдөлгөөнийг нээхдээ бүрэн хатуу хучилттай байдлаар эхний ээлжинд ашиглалтад оруулахаар гэрээнд тусгаж, компаниуд ч зөвшөөрсөн байсан юм. Гэвч дөрвөн шалтгаанаас төлөвлөсөн ажлаа хийж амжсангүй. Зарим компанийн гэрээг наадам өнгөрөөж байгуулсан, цаг уурын тааламжгүй байдлаас болж ажил зогссон, есөн хар цэг, олон суваг шуудуу гүүрний ажил давхцсан зэргээс шалтгаалсан. Хамгийн гол нь

**Ер нь амжуулах гэж л үзнэ дээ. Бид энэ өвөл хүн, хүч, техник тоног төхөөрөмжөө нэмэх талаар сайн бэлтгэж, өдөр бүрийн нарийвчилсан график гаргаж ажиллана гэж төлөвлөж байна.**

гэрээний үүргээ биелүүлэхгүй байсан компаниудын гэрээг цуцлах гэхээр төслийн төсвийг бүхэлд нь татчих гээд байсан учраас хойшилсон зүйл бий. Яамны зүгээс Азийн хөгжлийн банк болон төслийг хянаж байгаа Энэтхэгийн экспертүүдтэй уулзаж ажил цалгардуулсан компанийн гэрээг цуцлах, ирэх онд хугацаандаа ашиглалтад оруулах талаар ярилцаж байна. Энэ талаар гишүүдийн асуулгын үеэр нарийн мэдээлэл өгнө.

**-Өнгөрсөн зун Дарханы замд олон осол гарч иргэд амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөөрөө хохирсон. Одоо энэ байдал**

**засагдсан гэж үзэж болох уу?**

-Зун бороо их орсны улмаас түр замаар зорчиход хүндрэл гарсан нь үнэн. Одоо бол замын ихэнх хэсэгт нэгдүгээр үеийн цементэн хучилтаа хийчихсэн учраас автомашин эвдрэх зүйл гарахгүй болов уу. Харин асфальтан хучилт хийгээгүй хэсгүүдэд мэдээж ашиглалтад орсон хатуу хучилттай зам шиг толигор байхгүй нь ойлгомжтой. Гэхдээ замын хөдөлгөөний аюулгүй байдалд нөлөөлөхгүй.

**-Автомашинаа эвдсэн, эд хөрөнгө, эрүүл мэндээрээ хохирсон иргэдийн хохирлыг яах вэ?**

-Дарханы замаас болоод автомашинаа эвдсэн, хохирсон гэж үзэж байгаа бол хуулийн байгууллагад хандах эрх нь нээлттэй байгаа.

**-Замын ажлын гүйцэтгэл хэдэн хувьтай байгаа юм вэ,**

**Яг хэдэн км замд хатуу хучилт хийсэн бэ?**

-Бүрэн хатуу хучилтаа хийсэн зам 13 км л байгаа. Хүйтэрсэн учраас хатуу хучилт хийх боломжгүй болсон. Гүйцэтгэл 8-35 хувьтай байгаа. Гүүр, далангийн ажлын ихэнхийг нугалчихсан учраас гуравдугаар үеэ тавиад хучилтаа хийх боломжтой.

**-Гэрээндээ амжина гэдэгт та хэр итгэлтэй байгаа вэ?**

-Ер нь амжуулах гэж л үзнэ дээ. Бид энэ өвөл хүн, хүч, техник тоног төхөөрөмжөө нэмэх талаар сайн бэлтгэж, өдөр бүрийн нарийвчилсан график гаргаж ажиллана гэж төлөвлөж байна.

**-Ирэх хавар энэ замыг бас хаах уу?**

-Хатуу хучилт асфальт хийх үеэрээ хэсэгчлэн хааж, ажил гүйцэтгэнэ. Бүрэн хаахгүй гэсэн төлөвлөгөө гаргахаар ярилцаж байна. ■

## БАЙР СУУРЬ

## Эрхэм сайд та иргэдийн хохирлыг барагдуулж барах уу

Дархан-Улаанбаатар чиглэлийн зам хугацаандаа ашиглалтад ороогүйн бурууг салбарын сайд Б.Энх-Амгалан өөртөө хүлээсэнгүй. Харин ч тус зам дээр явж байгаад машинаа эвдсэн бол шүүхэд гомдол гаргаж болно хэмээн иргэдийг даапаалах маягтай тайлбар өгч байна. Дархан-Улаанбаатар чиглэлд зуны турш машин тэргээ эвдэж, тэр ч байтугай эрүүл мэнд, амь насаараа хохирсон иргэдийн бодит хохирлыг эрхэм сайд барагдуулж барах уу. Ажил хариуцсан хүмүүсийн буруутайгаас болж бүтээн байгуулалт хийгдээгүй тэр хугацаанд өдөр тутамдаа ямар бэрхшээлтэй тулгарч, хохирч байсныг дараах цөөн иргэдийн байр суурь бэлэн харуулна.

**МАНАЙ ЖОЛООЧ НАРЫН ДУНД МАШИНАА ТАВААС ДООШ УДАА ЭВДСЭН ХҮН НЭГ Ч БАЙХГҮЙ**

/Хот хоорондын тээврийн жолооч О.Батжаргал/

-Би сүүлийн дөрвөн жил жижиг тэргээр Дархан-Улаанбаатар чиглэлд тээвэр хийж байна. Манай тендерийнхэн /хот хооронд иргэд тээвэрлэх эрхтэй жижиг машины жолооч нарыг ийн нэрлэнэ/ дунд энэ зун машинаа гурваас доош удаа эвдээгүй хүн нэг ч байхгүй. Бид муу замаар арайхийн тээвэр хийж байгаа учир тээврийн үнээ нэмэхээс өөр аргагүй. Гэтэл иргэд үнээ дураараа нэмлээ гэж бидэнд уурладаг. Өдөр бүхэн Дархан-Улаанбаатар чиглэлд явж байгаа хүний хувьд хэлэхэд тэр зам дээр

ажил үнэхээр яваагүй.

**ТЭНХЛЭГ ТОХИРГОО АЛДАГДАХ НЬ ЭНҮҮХЭНД**

Баянзүрх дүүргийн иргэн Б.Мөнхбат

Улаанбаатар-Дархан-Улаанбаатарын чиглэлд тогтмол явж байна. Зам бол үнэхээр хэцүү. Машин тэсгээхгүй юм. Зам муутайгаас болж тэнхлэг тохиргоо алдагдах нь энүүхэнд. Ямарсайндаа сүүлдээ энэ замаас халшраад тойрч явдаг болоод байна. Хэрвээ Дарханы замаар яваад машинаа эвдсэн жолооч хохирлоо барагдуулж болно гэдэг нь үнэн бол сайхан л байна. Би ч бас хохирлоо барагдуулмаар л байна шүү дээ. Дарханы түр замаар явж эхэлснээс хойш би

гурван ч удаа машиндаа их, бага хэмжээгээр засвар хийлгэсэн.

**ДАРХАНЫ ЗАМААС БОЛЖ ЭРДЭНЭТИЙНХЭН ДАВХАР ХОХИРЛОО**

Орхон аймгийн Баян-Өндөр сумын иргэн Б.Болд

Би Улаанбаатар-Дарханы замаар дамжин аймгийнхаа иргэдийн Нарантуул захаас авсан ачаа барааг тээвэрлэдэг. Зам засварт орсноор Орхон аймгийн иргэд, тэр дундаа ачаа, бараа тээвэрлэдэг жолооч нарт хүндээр туслаа. Зунжин түр замд шаварт суух, халтиргаанаас болж машинаа хэд хэдэн удаа эвдсэн. Эвдэрсэн машинаа хаяад буцаад хот орох үе ч олон тохиолдсон. Тэр бүрт сэлбэг хэрэгслээ авч, засаж

янзалсаар ирсэн. Дарханы түр замд явахад голдуу амортизатор, таван бул зэрэг явах эд ангийн эвдрэл гарч байсан.

**МАШИНЫ ДУГУЙ ЭНЭ ЗУН, НАМАРЖИН ХАГАРЛАА**

Л.Төгөлдөр /Дархан-Уул аймгийн Шарын гол сумын иргэн/

-Улаанбаатар-Дарханы чиглэлд байнга явдаг. Зам сайхан болно гэж энэ зуны турш хүлээсэн. Сая зам ашиглалтад орлоо гэхээр нь явсан. Урьдынхаас дээшилж, дэвжсэн юм алга. Зам тавьсан компани нь их хариуцлагагүй хандсан юм байна гэж ойлгосон. Машины дугуй энэ зун, намаржин хагарлаа. Зам муутай болохоор машин дороо дуу ороод ирэх юм. ■

## МЭДЭЭ, МЭДЭЭЛЭЛ

## ТЕГ-аас “Монголын үндэсний фронт”-д шаардлага хүргүүлжээ

Тагнуулын ерөнхий газрын дарга Д.Гэрэл “Монголын үндэсний фронт” нэгдэлд албан шаардлага явуулжээ.

Албан шаардлагаар “Монголын үндэсний фронт” гэх албан ёсны бүртгэлгүй нэгдлийн удирдагчдыг Үндсэн хуульд

төрийн байгууллагын эсрэг үйл ажиллагаа явуулах, гэмт хэргийн шинжтэй үйлдэлд олон нийтийг уриалах, өдөөн

турхирах аливаа үйлдэл гаргахгүй байхыг шаардаж, хэрэв эдгээрийг зөрчсөн тохиолдолд Тагнуулын

байгууллагад хуулиар олгосон эрх хэмжээний хүрээнд арга хэмжээ авахыг мэдэгдсэн байна. ■



Д.Уламбаяр, ХИС-ийн Олон улсын харилцаа, нийгэм судлалын сургуулийн захирал др.проф.

# Дижиталчлалын үйл явцыг ухаарахуй

Монгол Улс шинжлэх ухаан, технологийн хөгжилд ДНБ-ийхээ 0.12 хувийг зарцуулж байгаа нь гайхмаар доогуур үзүүлэлт

## I. УДИРТГАЛ

XX зууны сүүлчийн улиралд хүн төрөлхтний хийсэн аугаа нээлт нь амьдрах геополитикийн орон зайгаа цоо шинээр, гэхдээ хязгааргүй “тэлсэн” явдал юм. Cyber space хэмээх хүний оюуны бүтээл болсон тулааны энэ шинэ орон зай хүн төрөлхтний амьдралд язгуур өөрчлөлт авчирч, цаашид ч олон өөрчлөлт, шинэ зүйлсийг буй болгох нь тодорхой болов. Хүн төрөлхтөн дижитал оюун ухаанд суурилсан аж үйлдвэрийн дөрөв дэх хувьсгалын босгон дээр нэгэнт иржээ. XX зууны сүүлч, XXI зууны эхнээс харилцан хамааралд суурилсан globalization эргэлт буцалтгүй болж байгаа тухай ихээхэн ярьж бичиж байсан. Харин эдүгээ дэлхий нийтийн хэмжээнд бүх салбарт digitization эргэлт буцалтгүй болж буй тухай, түүний хүн төрөлхтөнд үзүүлж буй нөлөөллийн тухай ярьж бичиж байна. Дижиталчлал эдийн засагт асар их хэмнэлт буй болгож, орон зай-цаг хугацааны тухай бидний stereotype-ийг орвонгоор нь өөрчилж эхлэв. Генетикийн түвшинд дижитал оюун ухаан бүтээхээс эхлээд асар том цахим хувьсгал өрнөж байна. Дубайн World Government Summit дээр хүний тархи болон түүний дижитал хувилбар хоёрын хооронд мэдээлэл солилцох хурдны тухай, тэдгээрийн нэгдлийн тухай өргөн хүрээтэй хэлэлцүүлэг өрнөх болов. Blockchain технологи хөгжлийн асар өргөн боломжийг нээж, 6G хэрэглээнд нэвтрэхэд ойрхон болов. Квантум компьютерын хөгжил цоо шинэ нөхцөл байдлыг буй болгохоор байна. Тэгвэл наад зах нь 10 жилийн дараа гэхэд технологийн хөгжлийн ямар ирээдүй биднийг хүлээж буй талаарх төсөөлөл тун бүрхэг байгаа юм. Тиймээс улс орнуудын өмнө даяаршиж буй дижитал ертөнцөд хэрхэн дасан зохицох тухай асуудал шинээр дэвшигдэн тавигдаж байна.

## II. E-REVOLUTION & E-WORLD

Хүн төрөлхтөн шинжлэх ухаан-технологийн урьд үзэгдээгүй ахиц, дэвшлийг Шинэ мянганд гаргах материаллаг болон оюун санааны үлэмж чадавхтай болов. Мэдээлэл, холбооны технологи, өндөр технологийн суурь байгууламж, дэд бүтэц, нэг хүнд ногдох нийтийг хамарсан өндөр хурдны интернетийн сүлжээ, гол эдийн засгийн бүтцүүдийн хоорондох интеграцлал, инновацчилал улс орны хөгжлийн гол хэмжүүр болжээ.



2017 оны 11 дугаар сард шинээр сонгогдсон БНСУ-ын Ерөнхийлөгч Мүн Жэ-инийн дэргэд байгуулагдсан Аж үйлдвэрийн IV хувьсгалын Хороо «e-World: Towards Digitization» сэдэвт олон улсын томоохон форумыг анх удаа зохион байгуулжээ. Энэ үеэр шинээр эмхлэн байгуулагдсан Шинжлэх ухаан, мэдээлэл, харилцаа холбооны технологи, ирээдүй төлөвлөлтийн сайд Юү овогтын (Yu Yeoung-min)

тэмдэглэсэнээр: “Дэлхий ертөнц дижитал хувьсгалын үр дүнд үйлдвэрлэл технологийн хөдөлгөгч хүч хуваарилалт болон кибер ертөнцийн үйл явцыг хувирган өөрчлөөд зогсохгүй хүмүүсийн өдөр тутмын амьдралын чанар, хэв маягийг ч үндсээр нь өөрчилж байна” гэжээ. Гадаад худалдаа, үйлдвэр, эрчим хүчний сайд Пэйк овогт (Paik Ung-yu) хэлэхдээ: «Глобал эдийн засаг, үйлдвэрлэлийг үндсээр

нь өөрчилж буй гол хүчин зүйл, динамик нь e-revolution юм” гэжээ. Rockwell International группын тэргүүн бөгөөд CEO солонгос гаралтай америк Davis Dong тэмдэглэн хэлэхдээ: “e-manufacturing гэдэг нь мэдээллийн технологид суурилсан e-моделиар жолоодон тухайлбал, аварга цахилгаан станцын үйлдвэрлэлийг ч дижитал хувьсгалын үр дүнд кибер орчинд буй болгож, үлэмж том үйлдвэрлэлийн бодит бүтээмжийг буй болгоно” гэсэн байна. Энэ бол new economy буюу digital economy ажгуу.

**R&D-Д ХЭН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ ХИЙЖ БАЙНА, ТЭНД DIGITAL REVOLUTION ЯВАГДАЖ БАЙНА**

Европын цөмийн судалгааны байгууллагын нүсэр том байгууламж CERN-д эрчим хүчний асар том туршилт судалгаа хийгдэж байгаа бол АНУ-ын Ливерморин Үндэсний лабораторид (National Ignition Facility) 192 хүчирхэг хүчин чадал бүхий лазерын тусламжтайгаар халуун цөмийн инерцийн гинжин урвал явуулснаар 500 тераваттын эрчим хүч гаргаж авахаар ажиллаж байна. Гэтэл 2006 онд л гэхэд дэлхийн нийт хүн ам 16 тераватт эрчим хүч хэрэглэж байжээ. Нэг тераватт гэдэг нь 1 их наяд (10<sup>12</sup>) ватт ажээ.

Өндөр хурдны сүлжээний үйлчилгээнд тулгуурласан мэдээллийн дэд бүтэц буюу суурь байгууламж цогц бүрдэж буй нь амьдралын чанарыг үндсээр нь өөрчилж байгаа ажээ. Өндөр хурдны интернет үйлчилгээнд интеграцчилалдсан төрийн институци e-government-ийг нэгэнт буй болгож, энэ нь иргэдэд хамгийн хурдан шуурхай засаглалын үйлчилгээг санал болгож байна. Өндөр хурдны сүлжээний үйлчилгээнд холбогдсон олон мянган дунд, их, дээд сургууль өндөр зэрэглэлийн чанартай e-education тогтолцоог бий болгожээ. Олон улсын эдийн засаг, олон сая жижиг, дунд үйлдвэрлэгчид дижитал системд холбогдон e-commerce-т суурилсан b-to-b-гийн гарцтай

болов. Мэдээллийн технологид үндэслэсэн e-business нэмэгдсэн өртөгтэй application, platform-д суурилсан new business model, болон job opportunities, pipenv, python, fintech буй болгож, smart байх нь хангалтгүй болов. Гар утас бол компьютерээс гадна shopping center юм. Өндөр хурдны интернет сүлжээнд суурилсан on-line эмнэлгийн үйлчилгээ амьдралын чанарыг эрхгүй өөрчилж буй ажээ. Энэ бүгдийн үр дүнд Шинэ мянганы эхнээс хөгжингүй улс орнууд e-society-г байгуулж байгаа ажээ.

Дипломат ажиллагаанд оролцогч субъектүүд өргөжиж, худалдаа, эдийн засаг, хөрөнгө оруулалт, санхүү, зээл, мэдээлэл-холбооны технологи, хүрээлэн буй орчин, экологийн асуудал шинэ үүрэг гүйцэтгэх болсон нь сонгодог буюу уламжлалт дипломат ажиллагаа дангаар эдгээр асуудлыг шийдвэрлэх боломжгүй болов. Мөн digital diplomacy, digital secretariat, digital embassy, digital ambassador, on-line freedom буй болов. Facebook, twitter diplomacy улс орнуудын иргэдийн санаа бодол, сонгуулийн үйл явцад хүчтэй нөлөө үзүүлж эхлэв. Өнгөт хувьсгалын гол локомотив нь social media network гэдэг нь ойлгомжтой болов. Дижиталчлал батлан хамгаалах болон тагнуулын байгууллагуудын үйл ажиллагаанд маш хүчтэй нэвтэрч байна.

Үндэсний эдийн засаг дэлхийн зах зээлийн хуулиар зохицуулагдаж, үндэсний баялаг, түүхий эдийн нөөцөө захиран зарцуулах нь нэг улсын эрх мэдэл, хил хязгаараас шалтгаалахгүй болж, гадаад, дотоод бодлогын зааг ялгаа багасч байна. Цахим ертөнц ганцхан мэдээлэл солилцох хэрэгсэл байхаа хэдийнээ больж, өөр өөр соёл иргэншил, эдийн засаг, эрхзүйн тогтолцоотой 200 гаруй улс гүрэн интернетэд холбогдож хил хязгааргүй эдийн засгийн нэгдсэн нэг орон зай болон хувирав. Их гүрнүүд гадаад бодлогоо тодорхойлохдоо: economics of power буюу хүчний эдийн засаг, power of economics буюу эдийн засгийн хүч гэсэн 2 зарчмыг баримталж байгаа нь бүхэлдээ дижитал технологит суурилж байна.

Монгол Улс шинжлэх ухаан, технологийн хөгжилд ДНБ-ийн 0.12 хувийг зарцуулж байгаа нь гайхмаар доогуур үзүүлэлт болно. Манай өмнөд хөрш 2017 оны долдугаар сард «Дараа үеийн хиймэл оюун ухааны хөгжлийн төлөвлөгөө-2030», хойд хөрш 2019 оны аравдугаар сард «Хиймэл оюун ухааныг хөгжүүлэх Үндэсний стратеги-2030» баримт бичгийг тус тус батлан гаргажээ. АНУ, Европын холбоо, Хятадын тэргүүлэх их сургуулиуд “Хиймэл оюун ухааны бакалавр, магистрын түвшний боловсролын мэргэжлийн хөтөлбөрийг нэгэнт хэрэгжүүлж эхлээд байна.

➔ **Ургэлжлэл бий**



# Цахилгаан машиныг дэмжих бодлогоо татвараар баллах нь зөв үү

Шатахуунаар явдаг автомашины импортыг хязгаарлах бодлого хэрэгжүүлж байгаа

Б.Ганцэцэг, ЗГМ сонин

Монгол дахь Америкийн худалдааны танхимаас “МАДА” буюу Монголын автомашины Дистрибьюторуудын Ассоциаци, Зам тээврийн хөгжлийн яам болон НЗДТГ-тай хамтран байгаль орчинд ээлтэй автомашиныг Монголд нэвтрүүлэх талаар хэлэлцлээ.

Агаарын бохирдолд автсан манай улс цахилгаан машины хэрэглээг нэмэгдүүлэх нь чухал хэдий ч нэлээд бэрхшээл буй аж. Шатахуун хэрэглээт автомашинтай харьцуулахад цэнэглэх хугацаа их шаарддаг төдийгүй туулах зам богино, батарей үнэтэй, засвар үйлчилгээ нь нэвтрээгүй гэх мэт олон шалтгаан байна гэж холбогдох албаныхан онцоллоо. Иймээс манай улс энэ төрлийн тээврийн хэрэгслийг ойрын жилүүдэд өргөн хэрэглээнд нэвтрүүлэх боломжгүй гэв. Хэдийгээр цөөн тооны цахилгаан машин манайд бий ч цэнэглэх төвийн тоог ч олшруулж чадахгүй байгаа нь импортоор оруулж ирэхэд бэрхшээл үүсгэж байна. Гэхдээ ЗТХЯ цахилгаан автомашины хэрэглээг дэмжих бодлого баримталж буй. Тус яамны мэргэжилтэн Ц.Нэргүйбаатар “Автомашины яндангаас гарах хорт утаа Улаанбаатар хотын



Гэрэл зургийг С.Батсайхан

**АГААРЫН БОХИРДОЛД АВТСАН МАНай УЛС ЦАХИЛГААН МАШИНЫ ХЭРЭГЛЭЭГ НЭМЭГДҮҮЛЭХ НЬ ЧУХАЛ ХЭДИЙ Ч НЭЛЭЭД БЭРХШЭЭЛ БУЙ АЖ. АВТОМАШИНЫ ЯНДАНГААС ГАРАХ ХОРТ УТАА УЛААНБААТАР ХОТЫН АГААРЫН БОХИРДЛЫН 10 ХУВИЙГ ЭЗЭЛДЭГ.**

агаарын бохирдлын 10 хувийг эзэлдэг. Тиймээс байгаль орчинд сөрөг нөлөөтэй автомашины импортыг бууруулах, эдийн засгийн хэмнэлттэй машины хэрэглээг нэмэгдүүлэх бодлого баримтлан ажиллаж байгаа” хэмээв.

Гэтэл яндангүй машины зах зээлийг урд хөрш тэргүүлж байгаа. Тус улс агаарын бохирдлыг бууруулахын тулд шатахуун хэрэглэдэг машины тоог багасгах зорилт тавьж, цахилгаан машин худалдаж авбал 60 мянган юань буюу ойролцоогоор 9000 ам.доллараар урамшуулдаг юм байна. Мөн Япон улсад ч энэ тохиолдолд 3000-7700 ам.доллараар урамшуулдаг аж. Манай улс дээрх орнууд шиг

дэмжих зохицуулалт, эрх зүйн орчин үүсгэхээр зорьж буй ч багагүй цаг хугацаа шаардлагатай байна. Одоогоор зуун хувь цахилгаан хөдөлгүүртэйгээс хос хөдөлгүүртэй машинтай адил 50 хувийн онцгой татвар авч буй. Тухайлбал, манайд орж ирээд буй Nissan Leaf-ээс 800 мянган төгрөгийн татвар авч байна. Мөн цахилгаан машинаас байгаль орчин бохирдуулсны төлбөр авч байгаа нь зорьсон бодлогоо баллаж буйтай адил. Тиймээс татварыг багасгаж, бусад улс оронтой адил эрх зүйн таатай орчин бүрдүүлэх төдийгүй цаашлаад урамшууллын арга хэмжээ хэрэгжүүлж эхэлбэл иргэдийн худалдан авах сонирхол нэмэгдэх нь гарцаагүй. ■

МЭДЭЭ, МЭДЭЭЛЭЛ

## Сэлбэ дэд төвд барьсан 60 метр гүүрийг нээлээ

Г.Ханд, ЗГМ сонин

Сэлбэ дэд төвийн бүтээн байгуулалтын ажлын хүрээнд барьсан 60 метр гүүрийн барилга угсралтын ажил дуусч, өчигдөр хүлээлгэн өглөө. Сүхбаатар дүүргийн 14 дүгээр хорооны нутаг дэвсгэрт Чингэлтэйн үерийн хамгаалалтын суваг дээр баригдаж буй 60 метр, 30 метр, 24 метр урттай зэргэлдээ гурван гүүрийн ажлыг хийж байгаа билээ. Өнөөдрийн байдлаар 60 метр гүүрийн барилга угсралтын ажил бүрэн дуусч, 24 метр гүүрийн ажил 80 хувьтай, 30 метр гүүрийн ажил 65 хувьтай хэрэгжиж байна.

Цаашид уг гүүрнүүдийг холбосон 6.6км авто замын ажлыг хийх аж. Сэлбэ дэд төвд эдгээр гүүр, авто замын ажил дуусч ашиглалтад орсноор 7 буудал орчим болон зуслангийн замын ачаалал 30-40 хувиар буурна гэж албаны хүмүүс үзжээ. Дээрх ажлуудыг 2020 оны III улирал гэхэд бүрэн дуусгахад төлөвлөөд байгаа аж. Улаанбаатар хотыг 2030 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор “Гэр хорооллыг хөгжүүлэх, хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр” төслийг хэрэгжүүлж эхэлсэн билээ. Уг төсөл гурван үе шаттайгаар нийт есөн жилийн хугацаанд хэрэгжих юм. ■

## Татварын өртэй тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг хязгаарлана

Татварын ерөнхий газраас татвар төлөгчийн харилцааг зохицуулах журмыг хоёр үе шаттай хэлэлцүүлж байна. Энэ хүрээнд, тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг хязгаарлах журмын төслийг өчигдөр танилцууллаа. Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварыг иргэд хуулийн дагуу 100 хувь төлөх ёстой. Гэвч жолооч нарын 10-20 хувь нь албан татвараа төлдөг юм байна. Зарим иргэн автомашинаа хэрэглэдэггүй шалтгаанаар татвараа төлөхгүй байх, нэр шилжүүлэхэд татварын өртэй байсан зэргээс өр үүсэх тохиолдлууд гардаг

аж. Тэгвэл тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг хязгаарлах журмын дагуу татварын өр төлөх нэхэмжлэлд заасан хугацаанд төлөөгүй тохиолдолд хөдөлгөөнд оролцуулахгүй байх сануулга өгөх юм байна. **Татварын ерөнхий газрын Орлогын газрын татварын улсын байцаагч Д.Энхтуяа “Татварын 10 сая хүртэл төгрөгийн өртэй татвар төлөгчийн авто тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг ажлын тав хүртэл хоногоор хязгаарлах юм.** Энэ үед авто тээврийн хэрэгслийн бүрэн бүтэн байдлыг өртэй татвар төлөгч хариуцна” хэмээлээ. ■

## ЗГМ: ТОВЧХОН

### ■ ЦАГ АГААР

УЦУОШГ-аас энэ долоо хоногийн сүүлээр их хэмжээний цас орох тул халтиргаа гулгаа ихэсч, зам, даваа гүвээ хаагдахыг малчид, иргэд, тээвэрчдэд онцгойлон анхааруулж байна. Тодруулбал, энэ сарын 16-17-ны өдөр ихэнх нутгаар цас орж, хүчтэй цасан шуурга шуурч, хүйтний эрч чангарах аж.

### ■ ОРОН НУТАГ

Иргэний нисэхийн ерөнхий газар болон ЗТХЯ-наас Сэлэнгэ аймаг руу бага оврын онгоц нисгэх санал гаргажээ. Аймгийн удирдлагууд уг саналыг хүлээн авч, ирэх сарын 25-ны өдрөөс эхлэн Сэлэнгэ аймгийн төвд онгоц буулгахаар болсон байна.

### ■ СПОРТ

ОБЕГ-ын харьяа “Аврагч” биеийн тамир, техник спортын хорооны тамирчин О.Есүгэн залуучуудын Ази, тивийн аварга шалгаруулах боксын тэмцээний 57 кг-ийн жинд хүрэл медалийн болзол хангажээ. Тэрбээр маргааш мөнгөн медалийн төлөө Тайландын тамирчинтай өрсөлдөх юм.

### ■ ЗӨРЧИЛ

Гаалийн байгууллага энэ оны эхний есөн сарын байдлаар нийт есөн удаагийн тохиолдлыг илрүүлж, 4.5 кг мансууруулах бодис хураан авч, цагдаагийн байгууллагад шилжүүлжээ. Уг хэрэгт таван иргэн холбогдсоноос нэг нь гадаадын иргэн байжээ.

### ■ ШАЛГАЛТ

Төрийн албаны ерөнхий шалгалт энэ сарын 16, 19, 21-нд болно. Энэхүү шалгалтыг гурван чиглэлээр өгөх бөгөөд шалгалт тус бүртээ босго оноотой аж.

### ■ ГЭМТ ХЭРЭГ

Олны танил хүмүүсийн нэр, зургийг ашиглан хуурамч хуудас нээж, иргэдийг залилан мэхэлж байсан этгээдүүдийг Сонгинохайрхан дүүргийн цагдаагийн I хэлтсийн Эрүүгийн тасгийн алба хаагчид илрүүлэн шалгаж байна. Тэд дансандаа мөнгө байршуулуулах замаар иргэдийг залилдаг байжээ.



# Хэт хэрэглээнээс татгалзах Шведийн Лагом хандлага

Лагом гэх үгийг швед хэлнээс орчуулбал “хангалттай”, “яг таарсан” гэсэн утга илэрхийлдэг



✍ О.Даваасүрэн, ЗГМ сонин

**Ш**вед улсад сүүлийн жилүүдэд лагом гэх шинэ чиг хандлага төлөвшжээ. Улмаар тус улсыг Lagomlandet буюу Лагом улс гэж нэрлэх нь бий. Энэхүү хэв маягийн гол философи нь бүх зүйлийн тунг нь тааруулж, алтан дунджийг олон, тэнцвэртэй амьдрах юм. Өөрөөр хэлбэл, тус улсын иргэд эерэг мэдрэмжийг эд зүйл бус нийгэмд оруулж буй хувь нэмэр өгдөг гэж үздэг. Швед хүмүүс өдөр тутамдаа зөвхөн нэн шаардлагатай зүйлийг хэрэглэж, хэт их эд материалаар өөрийгөө хүрээлүүлэн, амьдралаа ачаалуулахаас татгалздаг. Энэ хандлага нь зөвхөн эд материал төдийгүй хүн хоорондын харилцаанд ч нөлөөлдөг гэнэ. Тухайлбал, швед хүмүүс ажил амралт, жаргал, зовлон гэх мэт эсрэг тэсрэг зүйлсийн тунг маш энгийнээр тохируулдаг онцлогтой.

Лагом гэх үгийг Швед хэлнээс орчуулбал “хангалттай”, “яг таарсан” гэсэн утгыг илэрхийлдэг. Тус ойлголт нь хоол, дизайн, байгаль орчин гэх мэт амьдралын бүх салбарт хэрэгждэг. Гэхдээ эл хандлага загварын салбарт хүчтэй ноёрхдог ба Шведийн ихэнх дизайнер бүтээлүүдээ лагом хэв маягаар бүтээдэг байна. Жишээ нь Acne Studios, Filippa K гэх зэрэг брэнд хувцас урлахдаа илүү деталь, хэт их чимэглэл хэзээ ч ашигладаггүй. Үүний оронд тэд өдөр тутам болон онцгой тохиолдолд ч өмсөхөд

тохиромжтой биед эвтэйхэн, минималист хувцас зохион бүтээдэг.

**Энэ хандлагын бас нэг гол зорилго нь хэрэглэгчдийг хүрээлэн буй орчинтойгоо зохицож амьдрахад уриалах юм.** Дэлхий даашгүй их материал цуглуулах нь экологийн тэнцвэрт байдлыг алдагдуулж, байгаль орчинд хор хөнөөл учруулдаг. Тиймээс хэрэглээнээс таашаал авах үзлийг улс нийтээрээ үгүйсгэж буй нь сайшаалтай.

**ЛАГОМ ХАНДЛАГА НЬ ЭД МАТЕРИАЛ ТӨДИЙГҮЙ ХҮН ХООРОНДЫН ХАРИЛЦААНД Ч НӨЛӨӨЛДӨГ ГЭНЭ. ШВЕД ХҮМҮҮС АЖИЛ АМРАЛТ, ЖАРГАЛ, ЗОВЛОН ГЭХ МЭТ ЭСРЭГ ТЭСРЭГ ЗҮЙЛСИЙН ТУНГ МАШ ЭНГИЙНЭЭР ТОХИРУУЛДАГ ОНЦЛОГТОЙ**

Лагом хэв маягийг төлөвшүүлж буйтай холбогдуулан IKEA брэнд Live Lagom хэмээх төсөл хэрэгжүүлж байжээ. Төслийн гол зорилго нь нийгэмд экологийн боловсрол олгож, байгальд ээлтэй бүтээгдэхүүн хэрэглэж хэвшихийг уриалах юм. Тэд аяныхаа хүрээнд эрчим хүчинд хэмнэлттэй чийдэн, зай гэх зэрэг байгаль орчинд ээлтэй гэр ахуйн эд зүйлс худалдаалах болсон. Дэлхий дээр зөвхөн хүн л амьдардаггүйг тунхаглаж буй лагом хандлага нь хүний шуналын эсрэг хэрэгжүүлж буй энгийн, хэрэгцээт арга юм.

Улс бүрд өөрийн гэсэн амьдралын хэв маяг бий. Түүнчлэн зарим улсын амьдралын философи бусад оронд нөлөөлөх тохиолдол ч олон. Тухайлбал, Япон улсаас гаралтай минималист хандлага өдгөө дэлхий нийтэд хэт хэрэглээнээс татгалзаж, эко, эрүүл амьдрахыг уриалаад буй. Швед улсын лагом хэв маяг ч мөн ижил утга санаатай. Гэхдээ амьдралын бүх элементэд нөлөөлдөг болохоороо онцлог юм. ■



## Лагом хандлагад суралцахуй

“Амьдрал богино” гэх үгийг та залхтлаа сонссон байх. Гэхдээ танд дахин сануулья. Амьдрал таны төсөөлж буйгаас ч богино. Хэт олон зүйлд анхаарал хандуулж, хэтэрсэн их зүйл цуглуулах цаг хугацаа бидэнд хангалттай байдаггүй. Тиймээс үнэтэй олдх хором бүрээ аз жаргалтай өнгөрөөж, илүү цэгцтэй, амар тайван амьдрахад туслах лагом хандлагад суралцах зарим аргаас хүргэе.

**1. “Багасга, дахин ашигла, дахин боловсруул” дүрэм:** Швед нь байгаль орчинд ээлтэй орнуудын жагсаалтад тэргүүлдэг. Учир нь тэд Reduce, Reuse, Recycle буюу багасга, дахин ашигла, дахин боловсруул гэх дүрмийг хэрэгжүүлдэг. Эл дүрэм нь ус ба эрчим хүчний хэрэглээг багасгах, эд зүйлийг олон дахин хэрэглэх, мөн хог хаягдлаа боловсруулах гэсэн гурван зүйлээс бүрддэг. Хэрэв та эхний хоёр дүрмийг амжилттай хэрэгжүүлж чадвал дахин боловсруулах хог хаягдлын тань тоо хоёр дахин багасах болно.



**2. Хэрэггүй зүйлсээ хая:** Та гэртээ ямар ч хэрэгцээгүй хэт олон эд зүйл байлгаснаас, чанартай, загварлаг ганц зүйл байршуулах нь орон зай хэмнээд зогсохгүй таны гоо зүйн мэдрэмжийг илтгэнэ. Мөн 20 ширхэг уруулын будагныхаа ганц, хоёрыг л хэрэглэдэг бол танд будагны саваа чөлөөлөхийг зөвлөж байна. Хайртай эд зүйлээ шууд хаяхад хүндрэлтэй бол дотны хүмүүстээ бэлэглэж болох юм.



**3. Шүүгээгээ цэгцэл:** Хувцас дүүрэн шүүгээгээ хар даа. Бүгдийг нь та өмсдөг үү, хувцаснууд чинь бүгд танд таалагддаг уу, хоорондоо зохицдог уу? Хэрэв аль нэг хариулт “үгүй” гэж гарвал өөрт хэрэгцээгүй, өнгө өнгийн хувцсаа сэлгэх цаг болжээ. Гэхдээ шинэ хувцас худалдаж авах бус өмсдөггүйгээ хаяарай. Эсвэл асрах төвд хандивлаж болох юм. Ингэснээр та хэрхэн гоёхоо хэдэн цаг эргэцүүлэхээ больж, өглөөгүүр бага бухимдана. Улмаар чөлөөлөгдсөн мэт мэдрэмж төрөх болно. Харин дахин хэрэггүй хувцаснуудтай болохгүйн тулд ухаалаг худалдан авалт хийгээрэй.



**4. “Үгүй” гэж хэлж сур:** “Үгүй” гэж хэлэх чадвар амьдралд маш том үүрэг гүйцэтгэдэг. Энэ мөн л лагомын тодорхойлолт. Хэрэггүй зүйлсээс татгалзан үнэхээр хэрэгтэй ажилд цаг заваа зарцуулах нь амьдрал тэнцвэртэй болоход дэмтэй. Мөн шаардлагагүй зүйлд зарцуулах цагаа хайртай хүмүүстээ зориулах нь амьдралын тэнцэл бий болгоход чухал юм.



**5. Юу таныг аз жаргалтай болгож байна, түүнийгээ хий** Бидэнд хийх ёстой болон хийхийг хүсдэг олон зүйл бий. Энэ хоёр ойлголтын хоорондох зайг багасгахыг хичээ. Мөн та бусдын хүлээлтийн дагуу амьдрах ёсгүй гэдгээ үргэлж санах хэрэгтэй. ■



# Үзэсгэлэнт У.Лаура



✍ О.Даваасүрэн, ЗГМ сонин


Өвөрмөц хийгээд, үзэсгэлэнт  
төрх, гоолиг биеэрээ  
олны анхаарлыг татаад  
буй модель У.Лаураг “Гоо  
сайхан” буландаа урилаа.  
Тэрбээр шинэхэн ээж  
хэдий ч галбираа хадгалсан  
хэвээр буй. Түүнчлэн энэ  
хугацаанд загвар өмсөгчийн  
ажлаасаа хөндийрөөгүй.  
Хуульч мэргэжилтэй ч  
моделиор ажиллаж байгаа  
түүний алсын зорилго нь  
улс, эх орондоо хийсэн зүйл,  
хэлэх үгтэй нэгэн болох гэнэ.

- **Биеийн жин:** 58кг
- **Биеийн өндөр:** 172см
- **Биеийн харьцаа:** 91:60:90
- **Биеийн хамгийн дуртай хэсэг:** Мөр, нуруу
- **Орд:** Охин
- **Төрсөн он, сар, өдөр:** Нууц
- **Нүдний өнгө:** Гүн цэнхэр
- **Үсний өнгө:** Хар
- **Төгссөн сургууль:** Отгонтэнгэр их сургууль, БНХАУ-ын Соёлын сургууль
- **Ажил:** Модель, маркетинг менежер хийдэг. Мөн онлайн шоп ажиллуулж байна.
- **Мэргэжил:** Хуульч
- **Идэх дуртай хоол:** Эмээ, ээжийнхээ хийсэн хоол
- **Дуртай сүрчиг:** Эрэгтэй үнэртэнд дуртай.
- **Дуртай өнгө:** Номин ногоон
- **Хобби:** Чимээгүй орчинд, дуртай зүйлээ хийх
- **Зорилго:** Нийгэм, улс оронд хэрэгтэй хүн байхыг зорьдог
- **Дуртай брэнд:** Брэнд сонирхдоггүй.
- **Баримталдаг зарчим:** Шударга, энэрэнгүй байх
- **Утасны дэлгэцэн дээрх зураг:** Өвөөгийн зураг
- **Багын хоч:** Тугал, Lebron James



# “Мишлений одтой Монголын хамгийн анхны тогооч болохыг хүсдэг”

Сархинагтай шөлийг ЮНЕСКО-д бүртгүүлнэ



Т.Намуунболор, ЗГМ сонин

Энэ удаагийн “Залуус” буландаа “Ningbo international young chefs challenge 2019” тэмцээний хүрэл, “Chinggis khaan challenge cup”, “Chinese Potato champion” тэмцээний аварга О.Цэнгүүнийг урьж оролцууллаа. Мэргэн бууч болох мөрөөдлөө орхиж тогооч болсон энэ залуу ажлын гараагаа аяга угаагчаас эхэлж байсан гэдэг. Одоо тэрбээр Caelum Saferante рестораны Ерөнхий тогоочоор ажилладаг.

**-Таныг анх өөр мэргэжлээр суралцаж байсан гэж сонссон. Яагаад тогооч болсон юм бэ?**

-Би мэргэн бууч мэргэжлээр цэргийн сургуульд суралцаж байсан юм. Миний багын мөрөөдөл байлаа. Гараа хугалаад бүтэн жил өнжих хэрэгтэй болж, гэртээ нэг хэсэг гиюүрсэн л дээ. Тэр үед эгч маань “Чи ер нь зүгээр сууж байхаар ажил хий” гээд ресторанд угаагчаар оруулсан юм. Хувцсаа өмсөөд эгнэн зогссон тогооч нарын эмх цэгцтэй байдал, гал тогооны журам, миний хэзээ ч харж байгаагүй тансаг хоол шууд л сэтгэлийг минь татсан. Тэгээд л би тогооч больё, энэ л миний байх ёстой газар юм байна гэсэн мэдрэмж аваад мэргэн бууч

болох мөрөөдлөө орхисон доо. Ажлын гараагаа анх угаагчаас эхэлсэн. Угаагчаасаа бэлтгэгч, бэлтгэгчээсээ туслах тогооч, тогооч, ээлжийн тогооч, ахлах тогооч гэж ахисаар одоо Ерөнхий тогоочоор ажиллаж байна.

**-Энэ байр сууринд хүрэхийн тулд хэдэн жил зарцуулсан бэ?**

-Яг үнэнийг хэлэхэд тэр хугацааг тоолох зав байгаагүй ээ. /инээв/ Зургаан жил байх.

Ерөнхий тогоочоор ажиллаад жил болж байна. Угаагч хийдэг байхдаа тогооч ах нараасаа “Ах аа, энийг яаж хэрчихийг заагаад өгөөч, энэ хоолыг яаж хийдэг вэ” гэж асуугаад л оронд нь хувцсыг нь угаагаад өгье, амттай юм авч өгье, хоол хийж өгье гээд гуйдаг байлаа. Өнөөг хүртэл нэг ч удаа ээлжийн амралт авч үзээгүй. Заримдаа надад мэргэжил маань хайр дурлалаас ч илүү чухал санагддаг. Намайг угаагчаар

орж байхад ахлах маань ирээд ямар хоол хийж чадах талаар асуухад “Би будаатай хуурга, цуйван зэргийг бол хийж чадна” гэж хэлж байлаа. “За, чи юу ч гэсэн угаалган дээр ажилла. Хэр сайжирч, өсөж хөгжихийг чинь харъя” гэж байсан. Тогооч болж дэвших үед маань “Чамд авьяас байгаа. Хичээл зүтгэлээ битгий алдаарай” гэж хэлсэн нь надад том урам болсон.

**-Тогооч байхын хамгийн сайхан нь юу вэ. Ер нь та мэргэжлийнхээ ач холбогдлыг хэрхэн хардаг вэ?**

-Миний хийсэн хоолноос хүн таашаал авч, баярлаж идэж байгааг харах хамгийн сайхан байдаг. Дуучин Наран эгч манай байнгын үйлчлүүлэгч. Хийж өгсөн хоолыг маань “Ямар гоё юм бэ? Энэ хоолыг би сэтгэл зүрхээрээ амталж байна” гээд л үнэхээр таашаалтай иддэг. Тэр л мэдрэмжийг авахын тулд

хоол хийж байна. Тийм ч учраас мэргэжилдээ үнэхээр хайртай. Хүнийг хоолоор дамжуулан эмчилнэ, эрүүл зөв хүнсээр тэтгэнэ, дайлна. Энэ л миний мэргэжлийн ач холбогдлыг илэрхийлэх байх.

**-Таны нэрийн хоол юу вэ?**

-Миний өөрийн зохиосон 30 гаруй хоол бий. Тэр дундаас Самартай стейкийг онцолмоор байна.

**Монголын анхны Мишлений одтой тогооч болохыг хүсдэг. Энэ бол шилдэг ахлах тогооч нарт олгодог дэлхийн хамгийн нэр хүндтэй шагнал. Тамирчнаар ярих юм бол олимп гэсэн үг.**

**-Саваагүй гэмээр нэг асуулт асууя. Алдартай тогооч нарыг хараад байхад ихэнх нь эрчүүд байдаг. Гэхдээ гэр бүлийн хүрээнд эмэгтэйчүүд ахлах нь шүү дээ. Яагаад энэ салбарт эрчүүд манлайлж байна?**

-Хөгжилтэй талаас нь хариулбал бид төрж чадахгүй шүү дээ. Эмэгтэй хүн гэр бүл, үр хүүхэддээ цаг заваа зарцуулах

шаардлага биднийг бодвол арай их. Хүүхэд төрүүлээ гэхэд дор хаяж хагас жил гэртээ сууна. Энэ хугацаанд асар олон зүйл, шинэчлэгдэж, бусад тогооч нарын ур чадвар ч сайжирсан байдаг. Миний хувьд бараг л гал тогоотой гэрлэхсэн гэж хэлж болно.

**-Ойрын өдрүүдэд цас ороод нэлээн хүйтэн болж байна. Энэ өдрүүдэд уншигчдад маань санал болгох хоолны жор?**

-Цагаан гаа болон сармисыг санал болгож байна. Цагаан гааг сүүтэй холиод бага зэрэг цөцгий тавиад уугаарай. Дархлааг дэмжиж, өвлийг ханиадгүй давна.

**-Сүүлд оролцсон тэмцэнийхээ талаар сонирхуулаач. Манай Монголын тогооч нар маш амжилттай оролцсон байсан?**

-Долдугаар сард Хятад улсад зохион байгуулагдсан Chinese Potato champion тэмцээний залуучуудын ангилалд



Цагаан загасны мусс гэх энэ хоолонд хүний биед хэрэгтэй 16 нэр төрлийн витамин орсон бөгөөд дархлаа дэмжих зорилготой өвлийн улирлын special хоол юм.





Хоол чимэглэнэ гэдэг урлаг. Мэргэжлийн хэллэгээр үүнийг Fine dine гэдэг. Зурагт харагдаж буй Wellington steak гэх энэ хоол нь олон улсын тэмцээнээс хүрэл медаль хүртсэн юм.

Монголоос 10 хүний бүрэлдэхүүнтэй баг оролцсон. Ямар материалаар хоол хийхээ мэдэхгүй байсан ч очоод төмсөөр хоол хийх даалгавар авсан. Залуучууд маань хурдацтай хөгжиж, дэвшилтэт технологийг хэрэгжүүлж байна. Бүгд алтан медаль хүртсэн. Харин аравдугаар сард болсон олон улсын тэмцээнээс манайхан таван хүрэл медаль хүртсэн.

**-Хоол хүнс гэдэг аливаа улс орны соёлын нэг хэсэг. Монгол зоог, хооллох соёлыг олон улсад таниулах чиглэлээр залуу хүний хувьд бодож төлөвлөсөн зүйл бий юу?**

-Манай хооллох соёл их онцгой. Саяхан хятадууд сүүтэй цайг ЮНЕСКО-д бүртгүүлсэн. Бид энэ хавар Сархинагтай шөлөө соёлын өвөөр бүртгүүлэхээс гадна Гиннесийн номд давхар бүртгүүлэхээр ажиллаж байна. 21 аймгаас бүх тогоочдоо цуглуулж үндэсний хоолоо хамгийн олуулаа хийсэн амжилтыг эзэмших зорилготой. Манай ард түмэн малын бүх л шим тэжээлийг ашиглаж чаддаг. Гадаадынхан бол сархинаг гэж мэдэхгүй шүү дээ. Сархинаг бол нойр булчирхай, хоол боловсруулах эрхтэнд хамгийн сайн хүнс. Олон улсын

тэмцээний үеэр үндэсний хоолоо хийж өрсөлдөхөд манайх бүх л цомыг нь авдаг. Хоолон дотроос нь халуун чулуу гарч ирэхээр гайхшраад л /инээв/

**-Сүүлийн жилүүдэд Монголчуудын хооллох соёл өөрчлөгдөж, амьдралын буруу хэв маягтай болж байна. Монгол хоолны жор хүний эрүүл мэндэд хэрхэн нөлөөлдөг вэ?**

-Манай ард түмэн эрт дээр үеэсээ зөв хооллох маш том соёлыг тээж ирсэн. Өвлийн цагт хүнд хоол, махаа идэж, зуны дэлгэр цагт цагаан идээгээ идэж ирсэн шүү дээ. Энэ бол цэвэр эрүүл амьдралын хэв маяг. Харин өнөө цагт суурин газар амьдарч байгаа иргэдийн махны хэрэглээ хэт их байгаа нь эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж байгаа.

**-Олон улсад амжилт гаргана гэдэг бахархуштай зүйл. Тэгвэл цаашдаа ирээдүйгээ хэрхэн харж, ямар зорилго тавьж байна?**

-Монголын хамгийн анхны Мишлений одтой тогооч болохыг хүсдэг.

**-Мишлений од гэдгийг тайлбарлахгүй юу?**

-Энэ бол шилдэг ахлах тогооч нарт олгодог дэлхийн хамгийн нэр хүндтэй шагнал. Тогооч хүн бүрийн мөрөөдөл гэж хэлж болно. Тамирчнаар ярих юм бол олимпын аварга болж байна гэсэн үг.

**-Дээд зэрэглэлийн хоолны талаар танилцуулаач. Орчин, үйлчилгээний үнэлгээ, хүнсний бүтээгдэхүүний баталгаанаас гадна дээд зэрэглэлийн гэсэн мэдрэмжийг үйлчлүүлэгчид юу төрүүлдэг юм бэ?**

-Дээд зэрэглэлийн хоол нь хүний нэг хоолноос авах ёстой илчлэг, шим тэжээлийг нь тооцсон, ямар ч химийн бодис ашиглаагүй, бүх зүйлийг шинээр хийсэн байхаас гадна өнгө, амт үзэмжийн хувьд тогоочоос өндөр ур чадвар шаарддаг.

Тухайн хоолонд ямар нэг өнгө ашиглалаа гэхэд тэр нь зөвхөн хүнсний бүтээгдэхүүнээс гаргаж авсан байх жишээний.

**БИД ЭНЭ ХАВАР САРХИНАГТАЙ ШӨЛИЙГ СОЁЛЫН ӨВӨӨР БҮРТГҮҮЛЭХЭЭС ГАДНА ГИННЕСИЙН НОМД ДАВХАР БҮРТГҮҮЛЭХЭЭР АЖИЛЛАЖ БАЙНА. 21 АЙМГААС БҮХ ТОГООЧ НАРЫГ ЦУГЛУУЛЖ ҮНДЭСНИЙ ХООЛОО ХАМГИЙН ОЛУУЛАА ХИЙСЭН АМЖИЛТЫГ ЭЗЭМШИХ ЗОРИЛГОТОЙ. МАНАЙ АРД ТҮМЭН МАЛЫН БҮХ Л ШИМ ТЭЖЭЭЛИЙГ АШИГЛАЖ ЧАДДАГ. САРХИНАГ БОЛ НОЙР БУЛЧИРХАЙ, ХООЛ БОЛОВСРУУЛАХ ЭРХТЭНД ХАМГИЙН САЙН ХҮНС.**

**-Тогооч хүний гэрийн хоолны цэс ямар байдаг нь сонин байна. Ер нь тогооч нар гэртээ хоол хийдэг үү?**

-Хааяа л хийдэг юм. Ер нь ээж аавтайгаа уулзахаараа л гарынхаа хоолыг хийж өгдөг. Миний хийсэн хоолыг хараад аав, ээж хоёр маань итгэхгүй "Чи энэ хоолыг үнэхээр өөрөө хийсэн үү" гэж асууж байсан. Миний бодлоор тогооч нар гэрийн хоолонд илүү дуртай байдаг. Би ихэвчлэн будаатай хуурга хийдэг юм. /инээв/

**-Манай тогооч нарын ур чадвар ямар түвшинд байна вэ.**

-Хөгжлийн түвшингийн хувьд бид яг араас нь явж байна л гэж хэлнэ. Тийм ч их хоцроогүй.

Харин рестораниуд гал тогооны бүрэн тохижилт, зохион байгуулалтаас суралцах хэрэгтэй. Тухайлбал, хоол таваглах хэсэг, зөвхөн салат хийхэд зориулсан хэсэг гэх мэтчилэн. Манайд энэ шаардлагыг бүрэн хангасан гал тогоо цөөхөн байдаг. Мөн үйлчилгээний стандарт хангаагүй ресторан нэртэй газрууд олноор нээгдэж байгаад харамсаж явдаг. Жижигхэн хоолны газар ч бай, хүн мөнгөө төлөөд үйлчлүүлж байгаа учраас чанартай үйчилгээг л үзүүлэх хэрэгтэй.

**-Хэрвээ нууц биш бол таны хийж байсан хамгийн үнэтэй хоол ямар хоол байсан бэ?**

-395 мянган төгрөгийн үнэтэй Вагью стейк.

**-Хоол хийх урлагийг философигүйгээр ойлгох боломжгүй гэдэг. Таны философи юу вэ?**

-Миний хувьд хийж буй хоолондоо сэтгэл зүрхээ шингээхийг хүсдэг. Бүр нарийн яривал хоолныхоо нэг ширхэг материалд ч сэтгэлээсээ хандаж, хайрлах хэрэгтэй. Энэ материал миний хоолыг амттай болгоно, гайхалтай болгоно гэдэгт итгэж хийх нь чухал. Ганц помидороор ч гоё салат хийж болно.

**-Тань шиг хийх дуртай зүйлээ олоогүй хүмүүс манай ярилцлагыг уншиж байгаа байх. Залууст, тогооч болохыг хүсэж буй хүүхдүүдэд юу гэж зөвлөмөөр байна?**

-Өөрийнхөө үнэхээр сайн хийж чаддаг зүйлийг олоорой гэж хэлмээр байна. Юу ч хийж байсан эергээр харж, би энэ зүйлийг яаж хийвэл амжилттай болох вэ гэдэг талаас нь ажиллах хэрэгтэй. Би угаагчаар ажилд орохдоо будаатай хуурганаас өөр хоол хийж чаддаггүй байсан. Хүн хичээх юм бол хог цэвэрлээд ч амжилтад хүрч чадна. ■

ALBAN ECHN DISTRIBUTOR

**БОДИЗ АВТОМОТИВ**

THE AUTOMOTIVE EXPERTS

**Mazda CX-5**

**SKYACTIV TECHNOLOGY**

SALES@BODIZAUTOMOTIVE.MN

88111939, 88021939

WWW.BODIZAUTOMOTIVE.MN

WWW.FACEBOOK.COM/BODIZAUTOMOTIVE

Шатахууны бага зарцуулалт  
Хөдөлгүүрийн нэмэлт хүч



ХОНГ КОНГ өдөр бүр нислэгтэй




1.021.000₮




БҮХ НИСЛЭГТ ХОЁР ШИРХЭГ ТЭЭШ ҮНЭГҮЙ

☎ 333 999





## УХААЛАГ ХУДАЛДАН АВАЛТ



# ЗӨВ СОНГОСОН ОНЛАЙН ХУДАЛДАА САЙН ХЭМНЭЛТ БОЛДОГ

✍ Э.Батцэцэг, ЗГМ сонин

**М**онголчуудын худалдан авах соёл их өвөрмөц. Ямар ч төлөвлөлтгүй, сэтгэл хөдлөлөөр шийдвэр гаргах нь олонтаа. Ноосон оймс авах гэж дэлгүүр ороод дотуур хувцас, ор, дэрний цагаан хэрэглэл үзэж даамжирсаар шинэ загварын холигч аваад харьсан найз бүсгүй маань “хуучин блендерээ зарах юм сан” гэхтэй таарч л байлаа. Үр дүнд нь 2500 төгрөгөөр оймс авах төлөвлөгөө нь 250 мянган төгрөгийн зардал болж зуу дахин өссөн юм.

Баяжих нь хэмнэхээс эхэлдэг бол, хэмнэх нь худалдан авалтаа төлөвлөж, ухаалаг хандахаас шалтгаална. Дэлхий нийтээр тухайн жил, улирлынхаа хэрэгцээг, удтал төлөвлөж хүлээсэн зүйлсээ хямдралын үеэр авдаг болсоор удаж буй. Энэ нь өнөө үед онлайн худалдаанд шилжиж, ганцхан өдрийн хямдралд 38 тэрбум ам.долларын борлуулалт хийх хүртлээ хөгжив. Alibaba энэ их захиалгыг эздэд нь шуурхай хүргэхээр цаг минуттай уралдан

ажиллаж байх жишээний. Дашрамд сонирхуулахад, энэ жилийн Single's day-ийн орлого манай улсын төсвийн нэлээд хэдэн жилийн орлоготой тэнцэх юм.

**Харин монголчууд энэ том зах зээлд ямар тоглогч вэ**

Сүүлийн үед сошиал орчинд сурталчилгаа хийж, борлуулж байгаа бүх бараа нь “хүргэлттэй” гэдгээр давуу талаа тодорхойлж буй “ганзагынхан”-аар онлайн худалдааг ойлговол өрөөсгөл. Хүргэлтийн хэдэн төгрөг нэмж өгөөд “гэрээс гарч гэдэс алдалгүй” хүссэнээ авчруулахыг чухалчилдаг “залхуучуудыг”

онлайн худалдаачид онилдог. Тэдний олдог ашиг нь том тоо биш ч цалин харсан ажилтнаас дээр гэх.

Тэднээс арай ахисан түвшинд онлайн портал сайтаар захиалга авч, түүнийгээ гаднын (Хятадын голдуу) худалдааны сайтад уламжлан захиж замаар орлого олдог байгууллагууд бий. Шинэ

үеийнхэн голдуу үйлчлүүлдэг энэхүү худалдаа өнөөдөр эрчээ авч байна.

Монголын зах зээлд хараахан орж ирээгүй, технологийн хэрэгслүүд хамгийн их захиалгад дарагддаг. Компьютер, түүний дагалдах хэрэгслүүд, дрон, техникийн бусад сэлбэг зэрэг барааг

гаднын худалдааны сайтуудаас хямд үнээр авч байна.

Мөн Монголын зах зээлийн үнээс өндөр ч чанартай, оригинал барааг онлайнаар сонгож захиалдаг үйлчлүүлэгчид бий. Тэд брэндийн бүтээгдэхүүнийг улс дамжин очиж худалдан авахаас хялбар тул найдвартай вебсайтаар

захиалж авдаг.

Онлайн хэрэглэгчид сонголтоо зөв хийж чадвал цаг зав, мөнгөө хэмнэж байгаа тул улам бүр өргөжин тэлсээр байгаа юм. Дэлхий нийтийн чиг хандлагыг дагаад манайд ч энэ төрлийн худалдаа хамгийн ухаалаг худалдан авалт болох цаг ойрхон байна. ■

**Дэлхий нийтийн чиг хандлагыг дагаад манайд онлайн худалдаа хамгийн ухаалаг худалдан авалт болох цаг ойрхон байна.**

## БИЗНЕСИЙН ЗАРЧИМ

## Эрсдэлийн санд ашгийн 10 хувийг төлөвлө

Амжилттай яваа бизнес эрхлэгчдийн баримталдаг зарчмыг хэдхэн өгүүлбэрээр илэрхийлж болдог. Энэхүү буланд *ANNA sustainable Mongolian cashmere*-ийг үүсгэн байгуулагч, *Mongolian property management group*-ийн ТУЗ-ийн дарга, хатагтай Г.Ариунжаргалыг онцоллоо. Түүний бизнесийн зарчмыг сонирхъя.

Бизнесийн үйл ажиллагаанд төлөвлөлт хамгийн чухал. Төлөвлөөгүй зардал бизнесийг унагаадаг ганц зүйл. Маш нарийн бөгөөд хэдэн жилээр, улирлаар, сараар гэх мэтээр задалж төлөвлөдөг. Санхүүгийн төлөвлөлттэй зэрэгцээд эрсдэлийн сан заавал байх шаардлагатай. Энэ сангийн төсөв тухайн жилийн ашгийн 10 хувиас хэтрэхгүй байх шаардлагатай. Өөрөөр хэлбэл, төлөвлөөгүй зардал 10 хувиас хэтэрч болохгүй. ■



POST  
DRAMA

FAUST

CORPORATE CONVENTION CENTRE  
16,17th NOVEMBER, 2019





Монголын TOEFL & IELTS-ийн рекордыг манай суралцагчид тогтоодог



БОЛОВСРОЛЫН САЛБАРЫН  
2009 / 2012 / 2014 / 2015 / 2017

**ГРАНПРИ**



**АБСОЛЮТЫН АМЖИЛТААС...**

АБСОЛЮТ-н төгсөгч  
**Б.БИЛГҮҮН**  
TOEFL-ийн оноо: **117**  
University of California, 100% тэтгэлэг

АБСОЛЮТ-н төгсөгч  
**Э.РЭНЦЭНХАНД**  
TOEFL-ийн оноо: **116**  
Болгар дахь Америкийн их сургууль, 100% тэтгэлэг

АБСОЛЮТ-н төгсөгч  
**Г.ЦЭВЭЭНДОРЖ**  
TOEFL-ийн оноо: **110**

АБСОЛЮТ-н төгсөгч  
**Б.ДЭЛГЭРМАА**  
TOEFL-ийн оноо: **110**

АБСОЛЮТ-н төгсөгч  
**Б.БАЙГАЛЬ**  
TOEFL-ийн оноо: **105**  
Nanjing Forestry University 100% тэтгэлэг

АБСОЛЮТ-н төгсөгч  
**Б.БАТЭМҮҮЛЭН**  
TOEFL-ийн оноо: **105**  
Вашингтоны Их сургууль, 100% тэтгэлэг

АБСОЛЮТ-н төгсөгч  
**Б.ЦЭНГҮҮНЖАВ**  
Cornell University, Fulbright 100% тэтгэлэг

АБСОЛЮТ-н төгсөгч  
**С.ЭРДЭНЭБОЛД**  
Индианагийн Их сургууль, Харвардын Их сургууль 100% тэтгэлэг

АБСОЛЮТ-н төгсөгч  
**Н.ТЭРГЭЛ**  
University of British Columbia, 100% тэтгэлэг

АБСОЛЮТ-н төгсөгч  
**А.ЭНХЧИМЭГ**  
IELTS-ийн оноо: **8.0**  
University of Toronto, 100% тэтгэлэг

АБСОЛЮТ-н төгсөгч  
**Ө.ЭНХЖИН**  
IELTS-ийн оноо: **8.0**  
Nagoya University, 100% тэтгэлэг

АБСОЛЮТ-н төгсөгч  
**П.АРИУНАА**  
IELTS-ийн оноо: **8.0**  
Nagoya University, 100% тэтгэлэг

АБСОЛЮТ-н төгсөгч  
**Э.НАМУУНГОО**  
IELTS-ийн оноо: **8.0**

АБСОЛЮТ-н төгсөгч  
**Г.ТӨГСБИЛЭГ**  
IELTS-ийн оноо: **8.0**

АБСОЛЮТ-н төгсөгч  
**Ө.ЭНХЗАЯА**  
IELTS-ийн оноо: **8.0**

АБСОЛЮТ-н төгсөгч  
**Г.ЭНХЖИН**  
IELTS-ийн оноо: **8.0**

АБСОЛЮТ-н төгсөгч  
**Г.ХАЛИУН**  
IELTS-ийн оноо: **8.0**

АБСОЛЮТ-н төгсөгч  
**Б.ЦОЛМОН**  
IELTS-ийн оноо: **7.5**  
Итали улсын Засгийн газрын тэтгэлэг

АБСОЛЮТ-н төгсөгч  
**М.ТӨРБОЛД**  
IELTS-ийн оноо: **7.5**  
Arizona State University, тэтгэлэг

АБСОЛЮТ-н төгсөгч  
**А.ЭРДЭНЭ-ОЧИР**  
IELTS-ийн оноо: **7.5**  
Франц улсын Засгийн газрын тэтгэлэг

АБСОЛЮТ-н төгсөгч  
**Д.МӨНХБАЯР**  
IELTS-ийн оноо: **7.5**

АБСОЛЮТ-н төгсөгч  
**Б.ХҮСЛЭН**  
IELTS-ийн оноо: **7.5**

АБСОЛЮТ-н төгсөгч  
**В.ЯНЖИНЛХАМ**  
IELTS-ийн оноо: **7.5**  
DAAD 100% тэтгэлэг

АБСОЛЮТ-н төгсөгч  
**Г.ЦЭЦЭН**  
IELTS-ийн оноо: **7.0**  
University of Toronto, 100% тэтгэлэг



# Арктикийн мөс хайлж, далайн хавнууд тахалд автав

Цусны сорьцод үндэслэн 2003, 2009, 2013 онд дэгдсэн халдварын цар хариу, вирус тархсан арга замыг тодорхойлно



© EPA/Nick Cobbing / Greenpeace

О. Мишээл, ЗГМ сонин

**Далайн хав зэрэг Арктикийн бүсийн амьтдад аюултай, PDV вирусээр үүсдэг халдварт тахал өвчний тархцыг удаан хугацаанд ажиглан судалсан эрдэмтдийн судалгааны тайлан гарлаа.** Уг тахал ОХУ, Канадын эрэг орчмын далайн ус хайлах явц хурдассантай шууд уялдаатайг эрдэмтэд анхааруулж байна.

“Мөс хайлсаар байгаа нь PDV зэрэг өвчин үүсгэгч вирус тархахад хүргэлээ. Иймд далайн хавын тахал хэрхэн тархдаг, бусад амьтдад ямар халтайг яаралтай тодорхойлох шаардлагатай” хэмээн уг судалгааны ажлыг зохиогчийн нэг, Дэвид дэх Калифорнийн их сургуулийн экологич Элизабет ван Вормер мэдэгдэв.

Дэлхийн дулаарал хамгийн эмзэг тусах бүс нутагт Арктик, Антарктид мөсөн уулсынхаа хамт ордог. Сүүлийн жилүүдэд Арктик, Антарктидын бүс нутгийн жилийн дундаж температур зургаа, долоон градусаар өсөөд байна. Мөс цаашид үргэлжлэн хайлсаар байх аваас далайн урсгал ноцтой өөрчлөгдөж, дэлхийн уур амьсгалд эргэлт буцалтгүй хувиралт үүсэх юм. Хувирах процесс умард, өмнөд туйл орчмын бүс нутгийн экосистемд сүйрүүлэх нөлөө үзүүлж байгааг АНУ, ОХУ зэрэг улсын эрдэмтдийн судалгаа харуулав. Дэлхийн дулаарлын улмаас арктикийн араатан амьтад шувууны өндөг идэх, шувуун сүргийг бусниулах явдал хоёр дахин ихсэж, зуны усан бороо Антарктидын оцон шувууны олон төрөл зүйлийн ангаахай, дэгдээхий

үй олноор үхэж үрэгдэх шалтгаан болжээ. Саяхан хэд хэдэн газарт дэгдсэн “далайн хавны тахал” нь дэлхийн дулаарал нийт Арктикийн экологид нөлөөлж буйн шинэ жишээ юм.

Ердөө 1980-аад оны дунд үеэс тархсан энэхүү тахал өвчин Европ тивийн умард эргээр оршин амьдардаг олон арван мянган далайн хавын амийг авлаа. Аляскийн баруун эрэг орчмын далайн халиу зэрэг амьтдад 2004 оноос халдварлан үхүүлж эхлэхээс өмнө эрдэмтэд Еврази, Умард Америкт уг өвчнийг илрүүлж байсан удаагүй. Эрдэмтэд өдгөө 3,000 орчим амьд, үхсэн далайн хавнаас цусны дээж авчээ. Цусны сорьцод үндэслэн 2003, 2009, 2013 онд дэгдсэн халдварын цар хариу, вирус тархсан арга замыг тодорхойлно. ■

## Цаасан савлагаа хуванцраас илүү аюултай

Үйлдвэрлэлийн явцад хуванцраас илүү хорт бодис, хүлэмжийн хий ялгаруулдаг учраас цаасан уут сав нь хуванцар уутыг орлох учиргүйг Greenpeace-ын ОХУ дахь салбарын “Тэг хаягдал” хөтөлбөрийн эксперт Дмитрий Нестеров анхааруулж байна.

“Цаасаар хийснийг оролцуулаад нэг удаагийн хэрэглээний зүйлсээс татгалзах нь зүйтэй. Хуванцрын үйлдвэрлэлтэй харьцуулахад цаасан уутны үйлдвэрлэлээс агаар мандалд ялгарах хорт бодис 70 хувиар, нүүрстөрөгчийн ялгарал гурав дахин, усны нөөц бохирдуулагч бодис 50 дахин их. Байгальд задрах процесс нь хоргүй бус. Байж болохуйц, шилжилтийн

шатны хувилбар нь дахивар ашиглаж, ялган ангилах явдал” хэмээн эксперт тайлбарлав.

Хуванцартай харьцуулах тохиолдолд цаас нь экологийн

хувьд илүү аюулгүй гэж хүмүүс ойлгодог. Гэтэл нэг удаагийн хэрэглээний бүтээгдэхүүний хувьд цаас нь илүү “бохир” эд болохыг Нестеров дурдсан юм. ■



## ОХУ хогноос түлш гаргадаг боллоо

ОХУ-ын Томскийн политехникийн их сургуулийн судлаачид ххуйн хатуу хог хаягдлын агуулга ихтэй композит түлш бүтээснийг *Journal of Environmental Management* сэтгүүл мэдээлэв. Шинэ төрлийн түлшийг хэрэглээнд нэвтрүүлснээр хог хаягдлыг дахин ашиглаад зогсохгүй цахилгаан станцуудаас агаар мандалд ялгаруулж буй хүлэмжийн хийн ялгарлыг үлэмж хэмжээгээр бууруулах боломжтой.

ялгарал 60, хүхрийн ялгарал 35 хувиар бага байгаа”-г тус их сургуулийн эрдэмтэн Дмитрий Глушков тайлбарлав.

Шинэ төрлийн түлшийг хэрэглээнд нэвтрүүлснээр хог хаягдал хуримтлагдах явцыг сааруулж, Энэтхэг, БНХАУ, ОХУ, АНУ, Европын том хотуудын экологийн нөхцөлийг сайжруулж болох юм.

Уг түвшинд ахуйн хатуу хог хаягдлын зэрэгцээ хэрэглэсэн тос, нүүрс баяжуулах, газрын



Амжилттай болсон туршилтын дүгнэлтээс үзвэл уг композит түлш ердийн дулааны цахилгаан станцын хэрэглээнд нийцэж байгаа юм.

“Мод, хуванцар, резин, картон, хүнсний хаягдал зэрэг төрөл бүрийн ахуйн хогийг нүүрс устөрөгч, органик устөрөгчтэй түлшинд нэмэлт болгон ашиглаж туршихад ердийн нүүрстэй харьцуулахад азотын ислийн

тос нэрэх, ус цэвэршүүлэх үйлдвэрлэлийн процессын хаягдал мөн орж байна. Дулааны цахилгаан станцын ашиглалтын дундаж хугацаа буюу 20 жилд ойролцоогоор 1.9 тэрбум тонн ахуйн хатуу хог хаягдал, найман тэрбум тонн нүүрс баяжуулалтын хаягдал, 13 сая тонн хэрэглэсэн тос “далд оруулах” боломжтой гэсэн тооцоог эрдэмтэд гаргажээ. ■

## Энэтхэг улс агаарын бохирдлын улмаас сургуулиудаа хаажээ

Агаарын бохирдол ноцтой хэмжээнд хүрсний улмаас Делийн бүх сургуулиудыг пүрэв, баасан гарагт амраахаар шийдвэрлэснийг Энэтхэгийн Statesman сонин мэдээлэв. Эрүүл мэндэд хөнөөлтэй агаарын бохирдлоос сэргийлэх үүднээс иргэдийг гадаа бага байж, гэрээсээ ажиллахыг засаг захиргаа зөвлөж байна.

Уг шийдвэр нь Делийн засаг захиргаа арваннэгдүгээр сард сургуулиудыг хоёр дахь удаагаа амрааж буй хэрэг боллоо. Агаарын чанарыг хэмждэг 500 нэгж хэмжээтэй хэмжүүрээр хэмжихэд Делийн агаар 467 байгаа юм. Харин 50 хүртэл нэгжийг эрүүл мэндэд аюулгүй “хэвийн”-д тооцдог байна. Шинэ

Делид агаарын температур буурч, салхигүй тогтуун байгаа нь экологийн нөхцөл муудахад хүргэжээ. Агаарын бохирдлыг багасгахын тулд эрх баригчид гал сөнөөгчдийг дайчлан агаарт ус цацаж чийглэх арга хэмжээ авч байна.

Энэтхэгийн нийслэлийн агаарын бохирдлын буруутан нь хөрш Пенжаб, Харьяна мужийн тариачдын үйл ажиллагаа. Хуулиар хориглодог ч тариачид ургац хураасныхаа дараа шинэ үрсэлгээнд бэлдэж талбайн сүрлийг шатаадаг нь агаар бохирдуулах гол эх сурвалж болдог юм.

Агаарын бохирдолтой холбогдуулан хотын тээврийн хэрэгслийн хөдөлгөөнд мөн хязгаарлалт тогтоогоод байна. ■



# ЭДИЙН ЗАСАГ

- ⊕ Хүмүүн капитал үнэгүйдсээр байна ➔ 17
- ⊕ ВGI-д ажилладаг хүн 99-өөс өндөр наслах ёстой ➔ 19
- ⊕ Б.Чинбат: Үүрэн холбооны дөрвөн мянган дугаар бүртгэлгүй байгаа ➔ 18
- ⊕ Худалдааны зөрчил Японы эдийн засгийг удаашрууллаа ➔ 19

## ЗГМ: ТОВЧХОН

### ■ АРИЛЖАА

Монголын хөрөнгийн бирж пүрэв гарагийн үнэт цаасны арилжаагаар 30 компанийн 1,776,022 ширхэг хувьцаа арилжлаа. Энэ өдөр 13 компанийн хувьцааны ханш өсөж, мөн тооны компанийнх буурлаа.

### ■ ИНДЕКС

ТОП 20 индекс 0.08 хувиар буурч, зах зээлийн үнэлгээ 2.5 их наяд төгрөг боллоо.

### ■ ДААТГАЛ

Олон улсын даатгалын зохицуулагчдын холбооны 26 дахь чуулга уулзалт “Дижитал эрин дэх хяналт” сэдвээр тавь дахь өдрөө АНЭУ-д үргэлжилж байна.

### ■ ХЭЛЦЭЛ

# 55.95

Хувь. Монголын хөрөнгийн биржийн хоёрдугаар ангилалд бүртгэлтэй “Атар Өргөө” компанийн 97,423 ширхэг энгийн хувьцаа буюу нийт энгийн хувьцааны 55.95 хувийг “Таван богд инвест” компани худалдан авах санал гаргалаа.

### ■ ТАЙЛАН

# 638.4

Мянган канад доллар. “Эрдэнэ Ресурс Девелопмент Корпорэйшн” компани энэ оны гуравдугаар улирлын санхүүгийн тайлан болон Хөндий алтны төслийн талаар танилцууллаа. Тус компани тайлант хугацаанд Европын сэргээн босголт, хөгжлийн банкны оролцоотой найман сая канад долларын санхүүжилтийн гэрээ байгуулсан байна. Компанийн алдагдлын хэмжээ 638.4 мянган канад долларт хүрсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад буурчээ.

### ■ АЗИ

# 3.24

Сая. БНСУ-ын автомашины гарц сүүлийн есөн жилийн доод түвшинд хүрэх төлөвтэй байна. Үүний зэрэгцээ дотоод, гадаад дахь борлуулалт нь буурч байгаа юм.

# Бүтээн байгуулалтаар “бялуурах” 2020 оны төсвийн зарлагатай танилц

Өр зээлийн дарамт эдийн засагт өндийх сэхээ өгөхгүй нь. Бүтээн байгуулалтаас илүү олон улсад төлөх өндөр дүнтэй бондуудын эргэн төлөх хугацаа хамар дор ирлээ.



✍ Б.Баяртогтох, ЗГМ сонин

**М**онгол Улсын нийгэм, эдийн засгийн хөгжлийг тодорхойлох бодлогын чухал баримт бичиг хууль болон хэрэгжиж, 2020 оны төсвийн жил эхэллээ. Ирэх хавартай уралдан улс даяар бүтээн байгуулалт ундарч, сонгуулийн өмнө их ажил олох нь **13.8 их наяд төгрөгийн зарлагатай төсвийн ид шид гарч, тэр тусмаа орон нутагт сургууль, цэцэрлэг, эмнэлэг, соёлын төв, спорт заал олноор барихаар болов.** Нийгмийн салбарын 600 орчим барилга байгууламж ашиглалтад орохоор байна.

Барилга, дэд бүтцийн салбарт үйл ажиллагаа явуулж ирсэн

компаниудад 2020 оны төсөв хамгийн том ажил олгогч болж байна. Цаасан дээр буусан эдгээр бүтээн байгуулалтыг эхлүүлэхээр эрх баригчид шамдах нь дамжиггүй. Ингэж байж сонгогчдоосоо оноо цуглуулах, дахин эрх мэдлийн сэнтийд залрах замаа засна гэсэн үг. Гэхдээ 2020 оны төсөв хоёр талтайг уншигч та гадарласан байх. Алдагдал нь ДНБ-ий 5.9 хувьтай тэнцэх төсөв бүтээн байгуулалтыг дэмжиж байгаа боловч тэр хэрээр импортын урсгалыг, улбаалаад валютын эрэлтийг нэмэгдүүлэх нь.

Манай улсын салбарын 600 орчим барилга байгууламж ашиглалтад орохоор байна. Том дүнтэй бондуудын эргэн төлөлт 2021 оноос яригдаж эхэлнэ. Хамгийн эхнийх нь

**УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ**  
(2017-2020 онд)

232

ЦЭЦЭРЛЭГ

---

156

СУРГУУЛЬ

---

53

ДОТУУР БАЙР

---

68

СОЁЛЫН ТӨВ

---

92

ЭМНЭЛЭГ

---

Нийгмийн салбарын барилга ашиглалтад орж байна

60


Нийгмийн салбарын барилга ашиглалтад орж байна

📷 Гэрэл зургийг Ж.Гэрэлчулуун

“Мазаалай” бонд. 10.875 хувийн хүүтэй, 500 сая ам.долларын өр төлбөр биднийг хүлээж байна. Өр зээлийн дарамт эдийн засагт өндийх сэхээ өгөхгүй нь. Бүтээн байгуулалтаас илүү олон улсад төлөх өндөр дүнтэй бондуудын эргэн төлөх хугацаа хамар дор ирлээ.

Бид хажуу айлд өртэй атлаа өөртөө шинэ хувцас авах айлын эзэгтэй шиг ашилж боломгүй. Адууныхаа хэрээр исгэр гэж үг бий. Төсвийн хөрөнгө оруулалт өмнөх жилүүдтэй харьцуулахад хоёр их наяд төгрөгт ихээхэн ойртсон. Нийслэлд гэхэд соёл урлагийн салбарын хөрөнгө оруулалтад 134.9 тэрбум төгрөг зарцуулахаар төсөвт тусгасан бол царцсан байсан барилга, байгууламжийг ашиглалтад оруулахад зориулж 23 төсөлд 22.8 тэрбум төгрөг төсөвлөжээ. 2018 онд хийсэн ажлынхаа санхүүжилтийг авч чадаагүй 38 төслийн 34.8 тэрбум төгрөгийг ирэх жилийн төсөвт багтаасан байна. ■





# Хүмүүн капитал үнэгүйдсээр байна

Хөдөлмөр эрхлэлтийн байгууллагад бүртгүүлснээр ажилгүйдлийг тооцох нь өрөөсгөл

Б.Мөнх-Эрдэнэ, ЗГМ сонин

Үндэсний статистикийн хороо аравдугаар сарын нийгэм, эдийн засгийн тайлангаа өнөөдөр танилцуулна. Монгол Улсын өнөөдрийн амьдралыг тоогоор өгүүлэх статистикаас хөдөлмөрийн зах зээл, ажилгүйдэл, ядуурал, төлбөрийн тэнцэл, гадаад худалдаа, инфляц, мөнгөний нийлүүлэлт тодорхой харагдах учиртай. Он гарснаас хойших арван сарын үзүүлэлт хэрхэн өөрчлөгдсөнийг эндээс тандаж болох юм. **Статистикийн тайлангаас гадна УИХ ирэх оны төрийн мөнгөний бодлогыг хэлэлцэн батлах хамгийн сүүлийн өдөр өнөөдөр.** Улсын хэмжээнд ажилгүйдлийн түвшин 6.6 хувьтай тэнцэж байна. Энэ оны хувьд ажилгүйдлийн түвшин буурсангүй, дээрх тоонд хэвээр хадгалагдлаа.

Ажиллах хүчний түүвэр судалгаагаар ажилгүйдлийн түвшин өнгөрсөн онтой харьцуулахад ялимгүй буурч байгаа. Эдийн засаг 7.3 хувиар өссөн нь хөдөлмөрийн зах зээлд эерэг нөлөө үзүүлсэн байна.

Гэвч улирлын шинж чанартай ажилгүйдэл хамгийн өндөр байгаа юм. Онцлох тоо гэвэл 2016 оноос хойш ажилгүйдлийн түвшин буурсаар дээрх түвшид иржээ. Хэрэв эдийн засгийн өсөлтөө манай улс тогтвортой хадгалсаар байвал ажилгүйдэл буурахаар байна. ДНБ-ий өсөлтөөс ажилгүйдэл үлэмж шалтгаалдаг.

Статистик мэдээллээр, энэ оны есдүгээр сарын байдлаар улсын хэмжээнд ажил хайгчдын тоо 30.4 мянга бөгөөд үүний 10 гаруй мянга нь ажилтай боловч өөр ажилд орох сонирхолтой иргэд байна. Хөдөлмөр эрхлэлтийн байгууллагад сар бүр шинээр бүртгүүлсэн иргэдийн талаас илүү хувь нь ажлаас чөлөөлөгдсөн болон халагдсан иргэд юм. Эдийн засаг ялимгүй сэргэсний үр дүнд “Ажилд урьж байна”, “Ажилд сонгон шалгаруулж авна” гэсэн гарчигтай зар цөөрсөн. Гэхдээ уул уурхайн салбарт ашиглалтын лиценз Засгийн газраас олноор хоморголон цуцлах болсноор олон иргэн ажилгүйчүүдийн эгнээнд шилжээд байгаа. Уул уурхай хэдий худалдаа, үйлчилгээний салбартай харьцуулахад цөөн

хүнийг ажлын байраар хангадаг боловч дундаж цалингийн үзүүлэлтээрээ улсын дунджаас өндөр байдаг.

Хөдөлмөр эрхлэлтийн

**АЖИЛГҮЙ ИРГЭДЭЭ НАСААР НЬ АВЧ ҮЗВЭЛ ЗАЛУУСЫН АЖИЛГҮЙДЭЛ ӨНДӨР ХЭВЭЭР БАЙНА. ДИЙЛЭНХ НЬ ИХ СУРГУУЛИАС АЖЛЫН БАЙРАНД ОЧИХ ХҮРТЛЭЭ БАГАГҮЙ ЦАГ ХУГАЦАА ҮРДЭГ БӨГӨӨД ЭНЭ ХООРОНД ОЛОН ЖИЛ АЛДСААР. ӨӨРӨӨР ХЭЛБЭЛ, МОНГОЛ УЛС ХӨДӨЛМӨРИЙН АСААР ИХ НӨӨЦ БОЛОМЖОО САЛХИНД ХИЙСГЭСЭЭР БАЙНА.**

байгууллагад ажил хайж бүртгүүлсэн иргэдээр өнөөдрийн ажилгүйдлийн түвшнийг тодорхойлно гэвэл ихээхэн өрөөсгөл гэдгийг эдийн засагчид хэлдэг. Тус байгууллагад бүртгүүлэхгүй атлаа өөрөө өөртөө ажлын байр бий болгоод эсвэл гадаадад ажил хөдөлмөр эрхлэхээр яваа залуусын тоо жилээс жилд нэмэгдсээр байгааг хөндсөн удаатай. Тэрчлэн эрхэлсэн тодорхой ажилгүй хүмүүс нийгэмд байсаар байгааг зарим судалгаа харуулдаг.

Ажилгүй иргэдээ насаар нь авч үзвэл залуусын ажилгүйдэл өндөр хэвээр байна. Дийлэнх нь их сургуулиас ажлын байранд очих хүртлээ багагүй цаг хугацаа үрдэг бөгөөд энэ хооронд олон жил алдсаар. Өөрөөр хэлбэл, Монгол Улс хөдөлмөрийн асар их нөөц боломжоо салхинд хийсгэсээр байна. Эрх баригч өнөөдрийн МАН 2016 онд сонгуульд орохдоо иргэдээ ажилтай, орлоготой байлгах эдийн засгийн бодлого хэрэгжүүлнэ гэж амласан. Гэвч ажилгүйдэл өндөр хэвээр байна. Сургуульгүй, ажил эрхлээгүй 100 гаруй мянган залуус байгааг эрх баригчид мэдэгдсэн. ■

## УУЛ УУРХАЙ

# Гашуунсухайт боомтоор гарч буй нүүрсний автомашины тоо өдөрт 600-700 орчим болж буурчээ

Т.Элиса, Шинжээч

БНХАУ нүүрсний жилийн импортоо 300 сая тонноос хэтрүүлэхгүй барих бодлоготой байгаа тухай мэдээлэл гарахтай зэрэгцээд Монголын нүүрсний гол боомтуудын экспорт буурлаа. Тавантолгойн бүлэг ордын нүүрсийг гаргадаг Гашуунсухайт боомтоор гарч байгаа нүүрсний автомашины тоо энэ сард өдөрт



600-700 орчим болсон байна. Өнгөрсөн сард өдөрт дунджаар 1000 орчим нүүрс тээврийн автомашин гарч байсантай харьцуулахад буурсан үзүүлэлт боловч өнгөрсөн оны мөн үетэй ойролцоо өөрчлөлт гэдгийг Гашуунсухайт боомтын гаалийн газар мэдээллээ.

Нарийнсухайтын бүлэг ордын нүүрсийг гаргадаг Шивээхүрэн боомтоор өдөрт 300-500 орчим









автомашин нүүрс тээвэрлэн гаргаж байна. Энэ нь өнгөрсөн оны мөн үеэс ойролцоогоор хоёр дахин буурсан үзүүлэлт юм. БНХАУ талын татан авалт болон хилээр нэвтэрсний дараа нүүрсээ битүү агуулахад хадгалах шаардлага тавьж эхэлсэн зэрэг нь үүнд нөлөөлсөн гэж боомтын захиргаа мэдээллээ. Харин Ховд аймгийн Булганы боомтын экспорт энэ сараас

эхлэн бүр мөсөн зогссон байна. Энэ боомтоор Mongolia Energy Corporation Хөшөөтийн нүүрсийг экспортолж гаргадаг. 2019 онд нийт 1.2 сая тонн нүүрс гаргасан нь өнгөрсөн оны бүтэн жилийн үзүүлэлт 700 мянган тонн байсантай харьцуулахад даваад байна. Харин оны үлдсэн хугацаанд БНХАУ-ын талын татан авалт бүрэн зогссон гэсэн мэдээлэл байгаа юм. ■

## ДОТООДЫН ЗАХ ЗЭЭЛИЙН ГОЛЛОХ ИНДЕКСҮҮД



## ДЭЛХИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ГОЛЛОХ ИНДЕКСҮҮД





# Б.Чинбат: Үүрэн холбооны дөрвөн мянган дугаар бүртгэлгүй байгаа

Сошиал орчин дахь монголчуудын хэрэглээ маш өндөр

✎ Б.Батманлай, ЗГМ сонин

Дэлхийн улс орнууд дижитал шилжилт хийж, технологийн шинэчлэл өдөр, цагаар өрнөж байна. Энэ цаг үед манай улсын мэдээллийн технологийн салбарын өсөлт, хууль эрх зүйн орчин, хяналт, хамгааллын асуудал чухал юм. Мөн жил ирэх бүр энэ салбарын орлого нэмэгдсээр байгаа сайн мэдээ байна. Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газрын дарга Б.Чинбаттай ярилцлаа.

**-Сүүлийн жилүүдэд харилцаа холбооны салбарын өсөлт тогтвортой нэмэгдэж байна. Энэ оны хоёрдугаар улиралд ямар дүнтэй байгаа вэ. Мөн жилийн эцсийн дүнд ямар хүлээлт байна вэ?**


-Харилцаа холбоо, мэдээллийн технологи, шуудангийн салбарын орлого жилээс жилд өсөлттэй явж байгаа. Хоёр жилийн өмнөөс нэг их наядын босго давсан. Энэ жилийн II улирлын байдлаар 640 орчим тэрбум төгрөгийн орлоготой ажиллаж байна. Жилийн эцсийн дүнгээр өмнөх жилийнхээс 10 орчим хувийн өсөлттэй гарах болов уу.

**-Өмнө нь харилцаа холбооны салбарт хэрэглэгч өндөр байсан бол одоо интернэт хэрэглэгчдийн тоо тасралтгүй өсөлттэй байна. Энэ өөрчлөлтөд бодлогын хувьд ямар чиг баримжаатай явж байгаа вэ?**


-2016 онтой харьцуулахад үүрэн холбоо хэрэглэгчийн тоо 40 хувиар өссөн. 3.1 сая байсан бол одоо 4.2 сая болсон байна. Үүнээс 3.3 сая хэрэглэгч ухаалаг утас ашиглаж байна. Мөн сүүлийн нэг жилийн дотор 4G хэрэглэгч 88 хувиар өссөн. 891 мянга байсан бол нэг сая 680 мянга болжээ. Энэ хэрээр дата хэрэглээ нэмэгдэж байна. Цаашид ч өсөх хандлагатай. Гэхдээ текст болон воис хэрэглээ төдийлэн буурахгүй, тоогоо хадгалсаар байгаа.




Холбооны салбарын орлого (сүүлийн 7 жилд, тэрбум төгрөг)



Интернэт байнгын хэрэглэгчид (сая.хүн)



Сошиал хэрэглэгч (мянган.хүн)



**-Танай салбар дэд бүтэц, шинэ технологид маш их хэмжээний хөрөнгө оруулалт шаарддаг. Энэ салбарт үйл ажиллагаа явуулж буй компаниудын хувьд ямар өөрчлөлт харагдаж байна?**

-Улс орон бүрт дижитал шилжилт явагдаж байна. Энэ шилжилтийг дагаад хэрэглээнд их өөрчлөлт ажиглагдаж байна. Мобайл датад суурилсан аппликейшнүүдийг их ашиглаж байгаа. Сошиал орчинд монголчуудын хэрэглээ маш өндөр. Үйлчилгээнээс гадна хэрэглээ нь дижиталд шилжиж байна гэсэн үг.

**-Хэрэглээнд зохицуулах шаардлага зүй ёсоор гарч байна. Сошиал орчны зохицуулалтад ямар бодлого барьж байна вэ?**

-Ялангуяа, өсвөр насныханд цахим орчинг хэрхэн зөв хэрэглэх вэ гэдэг асуудал хурцаар тавигдаж байгаа. Тоон бичиг үсэгтэн болгох үндэсний хөтөлбөрийг манай агентлаг боловсруулаад дуусаж байна. Монголчууд бүгд бичиг үсэг тайлагдсан, гэвч цахим орчинд хараахан чадаагүй байна. Тиймээс мэдээллийн эх үүсвэрийг ялган таньдаг байх, идэвхтэй зөв хэрэглэгч байх зэрэг мэдлэг зайлшгүй хэрэгтэй боллоо.

**-Цахим аюулгүй байдлын асуудал мөн хурцаар тавигдаж**

**байна. Энэ тал дээр хууль эрх зүйн ямар зохицуулалт шаардлагатай байна вэ?**

-Мэдээллийн аюулгүй байдал тулгамдаж байгаа хамгийн том асуудлын нэг. Манайд хууль эрх зүйн орчин туйлын хангалтгүй. Бид холбогдох байгууллагуудтай хамтран боловсруулсан Цахим мэдээллийн аюулгүй байдлын тухай хуулийг удахгүй УИХ-д өргөн барина. Мөн Цахим халдлагатай тэмцэх үндэсний төв байгуулах шаардлагатай. Хуульд энэ төвийн чиг үүргийг тодорхой зааж өгсөн.

**МОНГОЛЧУУД БҮГД БИЧИГ ҮСЭГ ТАЙЛАГДСАН, ГЭВЧ ЦАХИМ ОРЧИНД ХАРААХАН ЧАДААГҮЙ БАЙНА**

**-Саяхан нийгмийг цочроосон хятад иргэдийн цахим ажиллагаатай холбоотой үйл явц аюулгүй байдлыг нэн даруй хамгаалах нөхцөл боллоо. Бүртгэлжүүлэлт, хяналтын систем ямар байх ёстой вэ?**

-Цагдаагийн байгууллагаас

холбогдох мэдээллийг өгсөн. Манай салбартай холбоотой зүйл нь үүрэн холбооны операторын дугаар олноор нь авсан байдал. Энэ оны тавдугаар сард нэмэлт өөрчлөлт оруулсан Харилцаа холбооны зохицуулах хуульд үүрэн холбооны операторуудын дугаарыг заавал бүртгэлтэй болох асуудлыг тусгаж өгсөн. 2016 оноос энэ тал дээр ажиллаж ирсэн. Одоо байгаа 4.2 сая хэрэглэгчээс дөрөв орчим мянган дугаар бүртгэлгүй үлдсэн байна. Үүнийг бүртгэлжүүлэхээр холбогдох байгууллагууд идэвхтэй хамтран ажиллаж байна. Иргэд дугаараа бүртгүүлснээр цахим халдлагаас өөрийгөө хамгаалаад зогсохгүй, электрон худалдаа, үйлчилгээнд хамрагдах боломжтой.

**-Дэлхий дахинд технологийн салбарын компаниуд улам хүчирхэгжиж байна. Манай улсын эдийн засгаас давсан үзүүлэлттэй компаниуд төрөн гарсаар байна. Эдийн засагчид мэдээллийн технологийн салбарыг уул уурхайтай дүйцэхүйц болж ирнэ гэж үздэг. Харин дэмжих орчны хувьд ямар байна?**

-Бид өнгөрсөн хавар Оксфордын их сургуультай хамтран Монгол Улс дижитал шилжилтэд хэр бэлэн байгааг тандсан судалгаа хийсэн. Тайлангаас харахад дэд бүтцийн хувьд харьцангуй бэлэн болчихсон байна, харин хүний нөөцөө бэлдэх шаардлагатай гэж гарсан. Юуны өмнө дижитал шилжилтийг хөтлөх мэдээллийн технологи, харилцаа холбооны салбарын экспертүүд хэрэгтэй байна. Мөн энэхүү шилжилтэд оролцох хэрэглэгчдээ бэлдэх шаардлагатай. Аж үйлдвэрийн IV хувьсгал бол зөвхөн мэдээллийн технологийн салбарын асуудал биш, бүх салбарт хамаатай. Тиймээс бусад салбарынхан хэрэгцээ шаардлага зөв тодорхойлоод дижитал шилжилт хийх нь чухал гэдгийг судалгааны дүнд гаргаж ирсэн. ■

## УУЛ УУРХАЙ

### SouthGobi Resources \$2.1 саяын цэвэр ашигтай ажиллажээ

✎ Т.Элиса, Шинжээч

Овоот толгойгоос нүүрс экспортолж байгаа SouthGobi Resources компани III улиралд

ашигтай ажилласан байна. Тус компани III улиралд 800 мянган тонн нүүрс борлуулж, 12.8 сая ам.долларын орлого олсноор 2.1 сая ам.долларын цэвэр ашигтай

ажиллажээ. Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад SouthGobi Resources-ийн борлуулсан нүүрсний хэмжээ 100 мянган тонноор өссөн, орлого нь 39 хувиар нэмэгдсэн

байна. Жилийн өмнө алдагдал хүлээж байсан бол энэ оны III улиралд ашигтай ажиллажээ. Хэдий тийм боловч дунджаар авч үзвэл борлуулсан тонн нүүрс

тутмын үнэ нь найман центээр буурч, 35 ам.доллар болжээ. Тус компани энэ жил нийт дөрвөн сая тонн нүүрс экспортлохоор төлөвлөж байгаа аж. ■



# BGI-д ажилладаг хүн 99-өөс өндөр наслах ёстой

Мэтью Кэмпбелл

**Ш**ЭНЬ ЖЭНЬ дэх Хятадын генетикийн BGI Group компанийн төв байрнаа ажиллагсад эрүүл мэндээр сул байхыг зөвшөөрдөггүй. Чөлөөт төлөвлөлттэй оффисын уудам орон зайд суурилуулсан модон морь, дөрөөт дугуй, татаж түлхдэг хөшүүрэг зэрэг тоног хэрэгсэл дээр ажилтнууд эрчимтэй дасгал хийх ёстой.

Генийн судалгаагаар дэлхийд тэргүүлдэг, аварга компанийн нэг BGI-г хамтран байгуулагч, захирал, 65 настай Ван Жянь ажилтнуудынхаа хөдөлмөрийн бүтээмжийг өсгөхөөр эрүүл байх шахалт үзүүлж буй төдий бус. Тэрбээр компанийнхаа 6,000 ажилтныг үйлдвэрлэдэг бүтээгдэхүүнийхээ амьд, алхдаг сурталчилгаа болгох хүсэлтэй.

Мөрөөдлөө биелүүлэхийн төлөө тэрбээр хорт хавдар, зүрх судасны өвчин, деменц буюу зенөгрөх зэрэг олон өвчнийг эмчлэх генийн болон анагаах бүтээгдэхүүний дээжээс туршихыг ажилтнууддаа болоод ар гэрийнхэнд нь зөвлөдөг юм. Судалгаа оношилгооны дүн түгшүүртэй гарсан хүмүүсийг хяналтад байлгаж, урьдчилан сэргийлэх хөтөлбөрт хамруулдаг. Зөв оношилгоо, эрүүл амьдралын хэвшлийн ачаар Ван профессор төдийгүй BGI-д ажилладаг хүн бүр 99 юм уу илүү өндөр наслах ёстой. Үр дүнг харах хүртэл зай бий. Учир нь компанид ажиллагсдын дундаж нас ердөө 30 гаруй.

BGI-гийн үндсэн бизнес -



BGI-г үндэслэн байгуулагчийн нэг, захирал Ван Жянь

геномын секвенинг (genome sequencing) буюу геномын анхдагч бүтцийн дарааллыг тодорхойлох ажил нь цоо шинэ зүйл биш. Гэхдээ **геномын ухаан удахгүй орчин үеийн анагаах ухааны цөм болно хэмээн Ван үздэг.** Sequencing буюу дараалал тайлах ажил хямд төсөр, найдвартай болж, генийн судалгааны ололтыг эмчилгээнд хэрэглэх боломж ихсэн, Засгийн газрууд, ялангуяа БНХАУ-ын Засгийн газар дэмжиж байгаа нь профессор ингэж үзэх үндэс болж байгаа юм.

Арилжааны компаниуд өдгөө хүний ДНХ-ийн (дезоксирибонуклейны хүчил) өчүүхэн

хэсгийн нууцыг тайлж байгаа ч яваандаа хүний нийт геномын секвенинг нь тариа тариулахтай адил энгийн хэрэглээ болно хэмээн Ван тайлбарлав. Геномын тестийг хүний амьдралын турш, эрүүл мэнд, хоол тэжээлийн дадал зуршил, магадгүй амьдралын ханиа сонгохтой холбоотой шийдвэр гаргахад хүртэл хийдэг болно. “Өнөөгийн эмчилгээний ихэнх нь аж үйлдвэрийн хувьсгалын үеэс эхтэй, физик, химийн ухаанд түшиглэдэг. Хавдрыг үхүүлнэ, хордуулна, түлнэ. Харин бид жинхэнэ биологи руу эргэн буцаж байгаа хэрэг”.

## Худалдааны зөрчил Японы эдийн засгийг удаашрууллаа

Ёшиаки Нохара

**Японы эдийн засаг энэ оны гуравдугаар улиралд эрс унасан үзүүлэлттэй гарав. Учир нь худалдааны зөрчлөөс үүдэн экспорт буурч, хэрэглээний татвар (тайлбар: НӨАТ) өсгөхийн өмнөхөн худалдаа наймаа ихсэж бэлэн бүтээгдэхүүний нөөцийг багасгаад буй.**

Ерөнхий сайд Шинзо Абэ дэлхийн эдийн засгийн удаашрал, хэрэглээний татвар өссөний таагүй нөлөөнөөс Японы эдийн засгийг хамгаалах багц арга хэмжээ авч буй цаг үед энэхүү уналт тохиолдож байна. Солонгосоос ирдэг жуулчдын тоо огцом буурсантай уялдан Шинзо Абэд Токио, Сөүлийн худалдааны маргааны үр дагаварт анхаарал хандуулах шаардлага ч тулгарлаа.

Японы эдийн засаг гацсантай адил хэрэг болов. Эдийн засагчид Японы дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлтийг 0.9 хувиар таамаглаж байжээ.

Бизнесийн хөрөнгө оруулалт сайжирч, өнгөрсөн сард хэрэглээний татвар нэмэгдэхийн өмнөхөн хэрэглэгчдийн зардал өссөн ч шинжээчдийн таамагласнаас сул байв. Татвар өсгөхөөс өмнөхөн хэрэглэгчдийн зардал сулхан өссөнтэй уялдан **энэ улиралд ч тус улсын эдийн засгийн статистик тааруу гарах төлөвтэй.**

АНУ, БНХАУ-ын худалдааны дайны улмаас багассан дэлхийн эрэлт, Өмнөд Солонгостой өрнүүлж буй худалдааны маргаан, Хагибис хар салхины хөнөөлт үр дагавраас шалтгаалж Японы эдийн засаг удаашрах шинж орсон. Тиймээс ерөнхий сайд



Долоогоос есдүгээр сарыг хамарсан гуравдугаар улиралд дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлт өмнөх улиралтай харьцуулахад жилийн дүнгээр дөнгөж 0.2 хувийн өсөлттэй гарсан. Үүнийг Японы Засгийн Газрын Кабинет Оффис пүрэв гарагт мэдэгдсэн юм. Өмнөх буюу дөрвөөс зургадугаар сарыг хамарсан хоёрдугаар улиралд уг өсөлт 1.8 хувьтай байсныг харгалзан үзэх юм бол

хөшүүргийн багц арга хэмжээ авахаар болсон юм.

Эдийн засгийг урагшлуулахын тулд Засгийн газар зургаан их наяд иенээс (55 тэрбум ам.доллар) багагүй зардал төлөвлөх шаардлагатайг Японы эрх баригч нам болох Абэгийн намын нэр нөлөөтэй гишүүн саяхан тайлбарласан билээ. Гэвч хэмжээ, хугацааг тодорхой заасан албан ёсны мэдээ хараахан гараагүй байна.

## Австралид ажилгүйдэл гэнэт ихсэв

Бүтэн цагтай тогтмол ажлын байр 10,300-гаар, бүтэн бус цагтай ажлын байр 8,700-гаар цөөрчээ

Майкл Хит

Австралид ажилгүйдэл ихсэж, сүүлийн 17 сарын хугацаанд анх удаа ажлын байр цөөрсөн статистик гарсан. Энэ нь санаанд оромгүй зүйл болж, бодлогын хүүгээ бууруулсан төв банкны бодлого эдийн засгийг өсгөж чадаагүйг харууллаа.

Австралийн статистикийн хорооноос пүрэв гарагт гаргасан тайланг үзвэл, аравдугаар сард ажилгүйдлийн хувь хэмжээ

эдийн засагчдын таамагласан 5.2 хувь бус 5.3 хувьд хүрчээ. Ажлын зах зээл суларч буйн илрэл болж ажилгүй болон хагас ажилтай хүмүүсийн эзлэх хувь хэмжээ 0.3 хувиар өсөж 13.8 хувь боллоо.

Цаашид ажилгүйдэл 5.2 хувиас хэтрэх аваас ирэх хоёрдугаар сард Австралийн Нөөцийн Банк (RBA – Reserve Bank of Australia) бодлогын хүүгээ бууруулж, валютын ханш суларна хэмээн шинжээчид үзэж байна. Уламжлалт бодлогын

хэрэглүүрээ шавхаад дуусаж буй Австралийн Нөөцийн Банкны тэргүүн Филип Лоу экспортлогчдыг дэмжиж, инфляцыг өсгөхийн тулд ханш суларч буй валютынхаа нийлүүлэлтийг өсгөхөөс аргагүйд хүрэх бололтой.

“Австралийн ажиллах хүчний сүүлийн шинэ статистик бодлогын хүү өсөх магадлалыг нэг шат ахиуллаа” хэмээн дэлхийн ажлын байрны статистикийн Indeed Inc вэбсайтын эдийн засагч, урьд

нь Австралийн төв банкинд алба хашиж байсан Каллам Пикеринг анхааруулав.

“Эдийн засгийн өсөлтийг хангах гэвэл хөшүүргийн бодлого ахиу ашиглах шаардлагатай. Бодлогын хүүг бууруулах зэрэг мөнгөний уламжлалт бус бодлого, өөрөөр хэлбэл санхүү, зээлийн хөшүүрэг аль болох хэрэглэх нь чухал.”

**Австралид есдүгээр сараас хойш ажлын байр 19 мянгаар цөөрсөн нь эдийн засагчдын**

**15 мянгаар нэмэгдэх таамагас эрс зөрсөн хэрэг боллоо.** Бүтэн цагтай тогтмол ажлын байр 10,300-гаар, бүтэн бус цагтай ажлын байр 8,700-гаар цөөрчээ. Хагас ажилтай хүмүүсийн хувь хэмжээ 0.2 хувиар ихсэж 8.5 хувьд хүрлээ. Австралийн Нөөцийн Банк хөдөлмөр эрхлэлт, хөрөнгө оруулалтыг дэмжих зорилгоор зургадугаар сараас хойш бодлогын хүүгээ гурван удаа багасгаад байгаа ч үр дүн тааруу байгаа юм.



## ZGM DAILY

⊕ **Bumchimeg: Political influence may affect BoM's policy**  
Fx reserves and the depreciation of Mongolian tugrik are interdependent.

⊕ **SouthGobi Resources reports gross profit of USD 12.8 million**  
SouthGobi Resources Ltd. announced its financial and operating results for the three and nine months ended September 30, 2019.

# Parliament approves amendments to Constitution

Mongolia has revised its Constitution for the first time in 19 years



Image by Batsaikhan.S

✍ **Aminaa.U**, ZGM Daily

**A**mendments to the Constitution has been discussed and approved at the Parliamentary session with a 100 percent vote in favor of 64 MPs in attendance. However, the opposition party, or

the DP, did not participate in the final vote. **This amendment has been made for the first time in 19 years.**

**In the amendment, 35 articles have been adapted and the amendments that have been enacted in 2000 were revised.**

According to the new Constitution, Presidential term will be six

years, the Supreme Court judges will be appointed in every 12 years, and Prime Minister and the four Ministers of the Chamber will be able to work in the Parliament and the Cabinet simultaneously. Also, several more significant changes were made to the judiciary.

Provisions on mixed election

**IN THE AMENDMENT, 35 ARTICLES HAVE BEEN ADAPTED AND THE AMENDMENTS THAT HAVE BEEN ENACTED IN 2000 WERE REVISED.**

system were not supported. In 2012, the parliamentary elections held in a mixed system for the first time. It was followed by criticism that some politicians were chosen by the support of parties without sufficient support of citizens. Accordingly, the 2016 general election was held under the majority system. ■

## MARKETS

### Tavan Bogd Invest purchases 44 percent of Atar Urguu

**Tavan Bogd Invest LLC has acquired 76,713 shares, or 44 percent, of Atar Urguu JSC through a tender, according to the Mongolian Stock Exchange (MSE).**

The tender was conducted between September 26 and October 31 and each share was traded for MNT 60,200, bringing the total price of the bought shares to MNT 4.6 billion.

**Tavan Bogd Invest had previously made an offer to purchase the whole common shares or 174,136 shares of Atar Urguu, MSE Tier-II company, at an offering price of MNT 60,200**

**per share.** This offer was made in accordance to Provision 22.1.1 of the Securities Market Law, which states that an offer to purchase the shares of a company can be made by a shareholder of the company

alone or together with its connected persons, or else a person that is not a shareholder making an offer for the purchase of all or more than a controlling block of the shares of the company on a voluntary basis. ■



## ZGM: HIGHLIGHTS


## POLITICS

Prime Minister of Mongolia Khurelsukh Ukhnaa receives delegates headed by Sir Suma Chakrabarti, President of the European Bank for Reconstruction and Development.

## ECONOMY

Operating loss of Entrée Resources Ltd in the third quarter of 2019 equals USD 0.4 million which is comparable to the operating loss of USD 0.4 million a year earlier.

Top 20 index drops 0.08 percent, to 18,799.41 point. MSE A index decreases 0.46 percent, to 8,720.71 points. MSE B index increases 0.14 percent, to 7,661.97 points. Market cap stands at MNT 2.51 trillion.



## SOCIETY

According to a study by Mister Auto, a British auto parts company, Mongolia leads by traffic congestion in the world. Moscow, Pakistan Karachi, India's Kolkatta, Mumbai, and Lagos in Nigeria are among the top six.

The American Chamber of Commerce (AmCham) in Mongolia, in collaboration with the Mongolian Automobile Distributors' Association, organizes a workshop on Development of Eco-Transport in Mongolia, involving key stakeholders from the Ministry of Road and Transport Development and Ministry of Environment and Tourism and Ulaanbaatar City municipality.

Japanese International Cooperation Agency collaborates with the Authority of Fair Competition and Consumer Protection (AFCCP) in upskilling state inspectors of the authority and renewing the legal environment for fair competition in Mongolia. The works have been done in the first phase of the project for Enhancement of Fair Competition Environment in Mongolia.

School bus service is to be tested for 27 elementary schools in 33 routes within Ulaanbaatar, starting today, November 15.



Scan the QR code to visit the Official Gazette website.

## ZGM: INTERVIEW

## Bumchimeg: Political influence may affect BoM's policy

**Fx reserves and the depreciation of Mongolian tugrik are interdependent.**

✍️ Tenuun.A, ZGM Daily

**B**umchimeg Gungaa, Chief Executive Officer of Mongolian Economic Analysis and Research Center, sat down with the Official Gazette to discuss the BoM's monetary policy for 2020, foreign currency reserves, budget expenditure, and risks Mongolia is likely to face next year.

**-What shall be the main measures that the Bank of Mongolia would take under its monetary policy, considering the current economic situation of Mongolia?**

-The Bank of Mongolia submitted State guidelines for the Monetary Policy to the parliament estimating inflation rate to stand at 8 percent in the next year and 6 percent for the medium term. The Central Bank also aims to reduce foreign debt, working to increase Fx reserves

and reduce risk.

**-Even though BoM intends to raise Fx reserves, it already made intervention for several times, supplying the U.S dollars to the domestic market. How will it affect the reserves?**

-Fx reserves and the depreciation of Mongolian tugrik are interdependent. Therefore, people need to understand that the exchange rate will be fallen to increase the reserve. However, it is relatively stable so far. In the last month, the depreciation rate was one percent and 5 percent as of a year. To reduce Mongolia's overall risk and strengthen its Fx reserve, there shall be a 1-2 percent change in the exchange rate.

**-How long will the policy on raising the Fx reserve to continue?**

-Well, it depends on the political influence and independence of BoM's governance. The exchange rate of Mongolian tugrik weakens

**Implementing Central Bank's policies for a long time is the key factor to stabilize the economy. Unfortunately, Mongolia does not create the possibility.**



before the election and increases after the electoral process. Therefore, the Central Bank's policy may be changed due to the social environment.

**-Is the decision to discharge Bank of Mongolia's Governor before the resignation time is proper?**

-The governor of the Central Bank reformed after the parliamentary

elections and the new governor appoints a member of the Monetary Policy Committee. It creates uncertainty in policies and carries many other risks. Implementing Central Bank's policies for a long time is the key factor to stabilize the economy. Unfortunately, Mongolia does not create the possibility to do so by changing BoM's governor regularly. ■

## MINING

## SouthGobi Resources reports gross profit of USD 12.8 million

SouthGobi Resources (SGR) Ltd. announced its financial and operating results for the three and nine months ended September 30, 2019. The company recorded a gross profit of USD 12.8 million in the third quarter of 2019 with a USD 2.1 million net profit.

The improvement in profit from operations was principally attributable to the lower provision for doubtful trade and other receivables being made during the quarter, and a reversal of the impairment of coal stockpile inventories of USD 5.3 million, the report said.

**Compared to the same period of last year, coal sales of SouthGobi Resources rose by 100,000 tons, increasing the revenue by 39 percent. However, the average price of the coal was reduced by eight cents to USD 35 per ton.**

On August 26, 2019, SGR received a letter from the Mineral Resources and Petroleum Authority of Mongolia (MRAM) notifying



Image by Batsaikhan.S

that the company's three mining licenses for the Soumber Deposit have been terminated by the Head of Cadastre Division of MRAM effective as of August 21, 2019. The company believes the cancelation of the Soumber Licenses is

without merit. SGR is not aware of any failure on its part to fulfill its environmental reclamation duties as they relate to the Soumber Deposit.

The cost of sales consists of operating expenses and royalties,

share-based compensation expense, equipment depreciation, depletion of mineral properties and idled mining asset costs. Operating expenses in cost of sales reflect the total cash costs of product sold during the quarter.

In 2016, the SGR started its program to build a coal washing plant to upgrade the low-quality fractions of its run-of-mine coals to higher value and higher-margin products. The commissioning of the wash plant at the Ovoot Tolgoi mine was completed during the second quarter of 2019. On July 31, 2019, the company entered into an agreement with the wash plant operator regarding the operation of the wash plant which expires on December 31, 2019. However, there can be no assurance that the company will extend this agreement after the expiry date.

**After the announcement, stocks of SouthGobi Resources Ltd. fell 2.33 percent to HKD 0.84 since the start of trading on Thursday. ■**



# Үслэг эдлэлийг химийн бодисоор цэвэрлэж болохгүй

Өвлийн улиралд өмсөх хүрэм, булга, нэхийг гэрийн нөхцөлд арчлах тийм ч амар биш. Тухайн хувцсанд тохируулж зааврын дагуу, зохих журмаар цэвэрлэхгүй бол үнэтэй хүрмээ юу ч үгүй, муухай болгох энүүхэнд. Тиймээс ихэнх хүмүүс өвлийн хувцсаа хими цэвэрлэгээнд өгдөг. Гэхдээ байнга хими цэвэрлэгээ рүү “гүйх” нь санхүүгийн хувьд ихээхэн хохиролтой. Иймээс хямд өртгөөр гэрийн нөхцөлд өвлийн хувцсаа хэрхэн цэвэрлэх зөвлөгөөг хүргэж байна.



## Үслэг эдлэл

Үслэг шуба, малгай зэргийг онц шаардлагагүй л бол халуун индүүгээр индүүдэх, угаах, химийн бодисоор цэвэрлэхийг хориглодог. Хэрэв шубаны үс нь нэг талдаа бөөгнөрч, эсвэл хэлбэрт орсон бол та халуун сэнсээр 3-5 секунд орчим үлээлгэх хэрэгтэй. Үслэг эдлэлийг цэвэрлэх хамгийн энгийн арга бол тоос шороо, өлөн бохирдлыг нойтон салфеткаар арчиж авах юм. Мөн шигж орсон бохирдлыг тоос соруулагчаар соруулж болно. Түүнчлэн тэжээмэл амьтны үс самнадаг, тусгай



самаар үсийг сор болон чиглэлийн дагуу зөөлөн самнаарай. Хэрэв шубаныхаа өнгийг сэргээхийг хүсэж байвал тал аяга алимны цуун дээр тал нимбэгний шүүсийг шахаж, үүнийгээ шүршдэг саванд хийн шүршиж болно. Тэгэхдээ хэт норгож болохгүйг анхаараарай. ■

## Сөдөн болон сентфон хүрэм

Таны куртка толбо болчихвол, тухайн хэсгийг бодис ашиглан угаах боломжтой. Харин сөдөн куртканы хувьд гараар болон угаалгын машинаар угаахад доторх сөд нь нэг талдаа бөөгнөрөх зэрэг асуудал тулгарна. Иймд аль болох хуурай аргаар цэвэрлэх нь зүйтэй. Хэрэв таны хүрэм бензин эсвэл ямар нэгэн тос болсон бол урьдаар тухайн хэсгийг хүүхдийн талк эсвэл цардуулаар үрээрэй. Харин төрөл бүрийн энгийн толбыг нимбэгний шүүсээр арчих нь үр дүнтэй бөгөөд давхар хувцсанд шингэсэн таагүй үнэрийг ч мөн арилгадаг. Хир, эсвэл дагтаршсан толбыг угаалгын нунтгаар цэвэрлэнэ.

Ингэхдээ хэрэв куртка сентфон материалтай бол угаалгын бодистой усанд угаах, харин сөдөн материалтай бол тухайн хэсгийг угаалгын бодисонд дүрсэн алчуураар арчина. Хамгийн гол нь та хувцасныхаа шошгон дээрх угаах аргыг судлах хэрэгтэй. Бага хэмжээний бохирдолтой үед та куртканы өнгөн хэсгийг хөөстэй алчуураар жигд арчиж болно. Хэрэв хувцас бохирдол ихтэй бол савантай усанд угаах, сөдөн куртка бол савантай усанд сойзоо дүрж, бохирдолтой хэсгийг үрж угаагаарай. Дараа нь чийгтэй цэвэрхэн алчуураар арчиж авахад хангалттай. ■



## Нэхий

Таны нэхий хүрэм тоос болсон бол тоос сорогчоор хөнгөн соруулаад авч болно. Харин шинэхэн толбоны тухайд хатсаных нь дараа хатуу сойз эсвэл баллуураар баллуурдаарай. Мөн талхаар үрэх нь ч үр дүнтэй. Хэрэв толбо удаж дагтаршсан бол та устөрөгчийн хэт исэл, эсвэл аммиакийг алчууранд шингээж, толботой хэсгийг арчих хэрэгтэй. Харин нэхий хүрмээ жигд арчиж өнгө оруулахыг хүсвэл бага зэрэг аммиак шингээсэн порлоноор жигд хөнгөн арчих нь зүйтэй. Яаралтай нөхцөлд нойтон салфетка ашиглан тухайн хэсгийн бохирдлыг арилгах боломжтой. ■



## UGG гутлыг хэрхэн цэвэрлэх вэ

Эхлээд гутлаа гадна, доторгүй тоос сорогчоор соруулж цэвэрлэнэ. Ингэснээр гутланд шигдсэн элс, шороо, бохирдол бага ч гэсэн цэвэрлэгдэх юм. Дараа нь микро даавуун салфеткийг бүлээн усанд дүрж гутлын гадна талыг арчина, цэвэрлэх бодис нь зөөлөн орцтой байх ёстой. Тухайлбал, илгэн хувцас цэвэрлэдэг тусгай бодис (гель, нунтаг, шингэн) байж болно. Дараа нь арьсны дотор талыг нь цэвэрлэнэ. Гараараа хэдхэн удаа арчихад л хангалттай, хэтэрхий их

ширүүн арчих хэрэггүй. UGG гутлын гадаргуу дээр тогтсон хөөсийг цэвэрлэнэ. Хэрвээ анхны оролдлогоор гутал цэвэрхэн болсон бол хатаахаар орхино. Ингэхдээ гутлын дотор талд хуурай цаасан салфетка хийхээ мартуузай. Энэ нь таны гутлын хэлбэр алдагдахаас хамгаалж байгаа юм шүү. Мөн хурдан хатаах гэж байна гээд пааран дээр гутлаа тавьж огт болохгүй. Гутал бүрэн хатсаны дараа илгэн гутлыг уснаас хамгаалах тусгай бодис цацаж болно. ■



ЭНЭ ӨДРИЙН ЗУРХАЙ

# Загасныхан амьдралд нь ахиц авчрах ажилд орох магадлалтай



**Хонь /III.21-IV.19/**

Өнөөдөр сэтгэл түгшээсэн уур амьсгал авчирдаг хүмүүсээс болгоомжил. Түншүүд болон худалдан авагч нартайгаа тохиролцоходоо илүү хянамгай бай. Эрх мэдэлтэй холбоотой асуудлууд нууцлагдмал нөхцөлд явагдана. Яаж түвэгтэй нөхцөл байдлаас гарахаа бусдад харуул. Таны шийдвэрт гаднын муу нөлөө орохоос сэргийл.



**Мэлхий /VI.22-VII.22/**

Хүмүүст туслахаар гар сунгавал сайхан сэтгэлийг тань хэрэгтэй хүмүүс анзаарна. Харин үүнийгээ хэт түрий барьж нэр алдартай болоход ашиглах хэрэггүй. Ажил олгогчоос сайн нөхцөлтэй ажлын санал хүлээн авна. Гүнзгий сэтгэл хөдлөлийн нөлөө хайрын холбоог тодотгож байна. Хөгжилтэй зүйл болон бизнест ч зугаатай байж чадна.



**Жинлүүр /IX.23-X.22/**

Энэ үед хичээл сурлагын үйл явц жигдэрнэ. Эрдэм шинжилгээний ажил явуулах, туршилтад оролцох, мэргэжлийн хүмүүсээс мэдлэг, туршлага судлахад нэн тааламжтай. Үйл ажиллагааныхаа явцад бусад хүмүүстэй ашигтай тааламжтай харьцаа тогтоох хэрэгтэй байна.



**Матар /XII.22-I.19/**

Өнөөдөр таны бодсоноос таагүй өдөр болбол үүнийг хэт мухар сүсэгтэй холбон хүлээж авах хэрэггүй. Болж буй зүйлүүд таны сэтгэлд хүрэхгүй байлаа гээд уур цаараа ямар ч гэм буруугүй хүмүүст гаргахаас сэргийл. Хувирамтгай нөлөөлөл их байгаа тул таны эрч хүч нэлээд буурах бололтой. Энэ нь таны мөнгө санхүү, үл хөдлөх хөрөнгөтэй холбоотой асуудлуудад нөлөө үзүүлэх болно.



**Үхэр /IV.20-V.20/**

Гэр бүлийн асуудал болон өмч хөрөнгөтэй холбоотой харилцааг шийдэх хэрэгтэй болно. Гэр орны асуудлаа амжилттай дуусгах юм бол урьдын маргаантай асуудлууд ямар ч саадгүй бүтнэ. Хэрэглэж байсан эд хогшил болон цахилгаан хэрэгслээ солихоор бол өөрийн орлогодоо тохируулан сонголтоо хийх нь зөв.



**Арслан /VII.23-VIII.22/**

Гэрлэсэн хүмүүс нэг нэгийгээ сонсоход цаг гарга. Ялангуяа сүүлийн үед харилцаа чинь суларч байгаа гэдгийг анхаарах цаг иржээ. Өнөөдөр зөвхөн хөгжилтэй зүйлс бус бизнес ч зугаатай байж чадна. Гэхдээ бяцхан зүйлд том асуудал үүсгэж болзошгүй. Тиймээс та өөрчлөлтийг давахад бэлэн бай.



**Хилэнц /X.23-XI.22/**

Хэрэв та таагүй мэдрэмжтэй байгаа бол энгийн амьсгалын дасгал эсвэл йог бясалгал хийх шаардлагатай. Олон хүний өмнө материаллаг байдлаа засах асуудал тулгарах бололтой. Санхүүгийн байдлаа сайжруулахын тулд тодорхой зүйл хийх хэрэгтэй. Юу хийхээ судалгаанд тулгуурлан бодож үз. Балмад этгээдүүдэд уруу татагдаж болохгүй.



**Хумх /I.20-II.18/**

Өнөөдөр замын түгжрэлээс эхлээд олон саад бэрхшээл тохиолдох тул ажилдаа аль болох эрт гарахыг зөвлөж байна. Хамт ажилладаг хүмүүстэйгээ маргалдах хэрэггүй. Өөрийнхөө эрх мэдлийг бусдад харуулах гэж оролдох нь танд сайн зүйл авчрахгүй. Хэрэв асуудлыг шийдэхийг хүсч байгаа бол буулт хийхийг хичээ. Энэ нь таныг ажлаа хурдавчлахад туслах болохоос боломжийг бусдад олго гэсэн үг биш.



**Хамтатгах /V.21-VI.21/**

Та амьдралд хайртай гэдгээ өөртөө төдийгүй эргэн тойрныхондоо харуулах болно. Энэхүү хандлага гэр бүлийнхэнд тань сайнаар нөлөөлнө. Хүүхдүүдтэйгээ хамтдаа цагийг өнгөрөөхөд тохиромжтой. Хэрэв та өөртөө итгэвэл бусад зүйлээс үл шалтгаалан амжилтын оргилд хүрнэ. Магадгүй зарим өрөө барагдуулах боломжтой болно.



**Охин /VIII.23-IX.22/**

Энэ жил хийсэн бүхнээ дүгнэж эхлэх чухал үе. Та хэсэг хугацаанд ажиллаж, тодорхой үр дүнд хүрсэндээ сэтгэл хангалуун байна. Гэхдээ амсхийгээд дахин ширүүн тулаанд бэлдээрэй. Та хаана ч байсан нөхцөл байдлыг тодорхойлох нь тодорхой бус сэжмүүдийг цуглуулан нэгтгэж, сайхан үр дүнд хүрэх боломж олгоно.



**Нум /XI.22-XII.21/**

Өнөөдөр өөрийнхөө үзэл бодлыг ирээдүйн зорилгын төлөө шинээр тодорхойлоход таатай өдөр байх болно. Гэхдээ адал явдалд хэт дурлах хэрэггүй, зүгээр л ажлаа ном журмынх нь дагуу хий. Намтар түүхтэй танилцах, аяллын хөтөлбөр үзэх, өөр соёл иргэншлийн талаар судлах зэргээр мэдлэгийн хүрээгээ тэлбэл сэтгэл хангалуун байх болно.



**Загас /II.19-III.20/**

Өөрийн арга барилаа өөрчилснөөр ажлын чадвар тань нэмэгдэнэ. Та ирээдүйдээ их ахиц авчрах ажилд орж болзошгүй. Таны амьдралын өнгө төрх дээшилнэ. Санхүүдээ санаа зовж байгаа бол мөнгөө бага багаар ч болов хадгал. Гэвч энэ нь та хөгжилдөн зугаацахгүй бай гэсэн үг биш юм.

ДОРНЫН ЗУРХАЙ

## Үс засуулбал ЭД малын гарлагатай



**Наран ургах, шингэх:**  
07:57-17:18

**Үс засуулбал:**

Эд малын гарлагатай

**Барилдлага:**

Үл тохирох

**Шүтэн барилдлага:**


Хурьцахуй

**Суудал:** Үс

**Аргын тооллын арваннэгдүгээр сарын 15, Сугар гараг. Билгийн тооллын 18, Гөрөөсөн толгой одтой, улаан луу өдөр.**

Өдрийн наран 07:57 цагт мандан, 17:18 цагт жаргана. Тухайн өдөр хулгана, бич жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба бар, туулай жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Эл өдөр хууль цааз гаргах, батлах, хэрэглэх, хулгай дээрмийг номхтгох, гэмтнийг шийтгэх, мал адгуус номхруулах, угаал үйлдэх, бороо хур оруулах, зэтгэрийг номхтгох, хөгжмийн зэмсэг урлах, дарханы үйлд сайн. Гүүр тавих, газар шороо ухахад муу. Өдрийн сайн цаг нь бар, луу, могой, бич, тахиа, гахай болой. Хол газар яваар одогсод зүүн зүгт мөрөө гаргавал зохистой. Үс шинээр үргээлгэх буюу засуулахад тохиромжгүй.

ЗГМ: ҮГИЙН СҮЛЖЭЭ



13. Номхон далайд орших Индонезийн арлууд

14. Даавууны өргөний хэмжээ  
15. Ухаан, санамж

ХӨНДЛӨНГӨӨР:

2. Номхон далайн нэрийг өгсөн Португалын нэрт далайчин  
8. Үндэсний хөгжмийн  
9. Гэгээн ... наадам

11. Үндэс  
12. Хурдан морийг бэлтгэгч  
16. Леонардо да Винчийн алдарт зураг

ТАШУУГААР:

- 1. Узбек нутагладаг нэн ховордсон
- 2. Өндөр уулархаг газраар шувуу

БОСООГООР:

- 3. Бууны эд анги байрны шавьж
- 4. Италийн мөнгөн тэмдэгт 7. Лам санваартны өмсгөл, нөмрөг
- 6. Толгойгоо таслуулчихаад долоо хоног амьд байдаг орон 10. Д.Банзрагчийн алдарт роман

Өмнөх дугаарын хариу 11.14

	Э	Э	Л	З	Э	В	З	Э	Э				
Ш	Р	У	А	А	Х	Н	Б						
И	Л	Ү	Ү	Э	М	О	Ш	Н	У	Х	А	А	
Л	У	О	Б	И	Э	Б	Л						
Б	У	Л	Д	Р	У	У	Н	И	Р	В	А	Н	А
Ү	М	Б	У	Г	Х	А	Л						
Ү	Н	Э	Н	А	Л	Б	Т	О	А	Т	А	А	
Р	Н	Д	И	О	Э	А	Г						
	О	Д	О	О	Н	Я	Н	Х	И	Р	С		

ЗГМ: СУДОКУ

3	7		6				
			7	1			
6			4	9	5		
	7	9			6		8
	4	7	5				
		2				4	
		8	3				
7	1						
						6	4

Өмнөх дугаарын хариу

6	4	8	9	2	7	3	1	5
7	1	9	3	4	5	6	2	8
5	3	2	8	6	1	4	9	7
8	7	1	5	3	9	2	4	6
4	5	6	1	8	2	7	3	9
9	2	3	6	7	4	8	5	1
2	9	7	4	1	8	5	6	3
1	6	4	7	5	3	9	8	2
3	8	5	2	9	6	1	7	4





**ЗГМ: ТИР**

Аманд ороод хайлах мэт зөөлөн, чийгтэй кекс хийхийн тулд баримталдаг хамгийн чухал технологи бол хэрэглэх орцуудаа тасалгааны хэмд байлгах юм. Мөн бэлэн болсон кексээ чихэртэй ус (чихэргүй ч байж болно) цацаж чийглэх хэрэгтэй. Үүнээс гадна жигнэж байх үедээ цонх, балкон, хаалга зэргийг онгойлгож, салхилуулж болохгүй, яг нялх хүүхэд усанд оруулж байгаа мэт “халамжилж” жигнэх ёстойг санаарай.

# БРАУНИ СУУРЬТАЙ КЕКС

**ШИМ ТЭЖЭЭЛИЙН МЭДЭЭЛЭЛ:**

**Калори:** 5078 ккал  
**Нүүрс ус:** 716 гр  
**Ислэг:** 14 гр  
**Өөх тос:** 225 гр  
**Уураг:** 73 гр

**ОРЦ: БРАУНИ**


- Хар шоколад-140 гр
- Масло-50 гр
- Бор сахар-50 гр
- Өндөг-1 ширхэг
- Гурил-35 гр

**ОРЦ: КЕКС**

- Масло-120 гр
- Элсэн чихэр-100 гр
- Өндөг-2 ширхэг
- Гурил-120 гр
- Хөөлгөгч-2 гр
- Сүү-50 мл

**ХЭРХЭН ХИЙХ ВЭ:**

1. Талхны хэвээ тослоно, эсвэл калькан цаасаар бүрнэ.
2. Шарах шүүгээг 180 хэмд халааж бэлтгэнэ.
3. Браунийг хийхдээ эхлээд хар шоколад масло хоёроо зөөлөн гал дээр хайлуулна. Хайлсных нь аваад бага зэрэг хөргөж байгаад дээрээс нь бор сахараа хийж уустал нь хутгана.
4. Өндгөө хийж сайтар хутгана. Дээрээс нь гурилаа хийж хутгасны дараа хэвэндээ гоожуулж хийнэ. Шарах шүүгээнд хийгээд 15 минут болгож дараа гаргана.
5. Кексээ хийхдээ масло, элсэн чихэр хоёрыг хөвсгөр болтол миксердэнэ. Үүн дээрээ өндгөө нэг нэгээр нь хийж миксэрдэнэ.
6. Зуурмаг дээрээ гурил, backpulver (хөөлгөгч) хоёрыг шигшиж хийн хутгаад сүүлд нь сүүгээ нэмж хутгана.
7. Кекснийхээ зуурмагийг брауни дээрээ асгаж шарах шүүгээнд хийгээд 160 хэмд 25-30 минут болгоно. Шүдний чигчлүүрээр хатгаж болсон үгүйг шалгаад гаргана.



## Эдийн засаг, бизнесийн мэдээлэл 24 цагаар таны сонорт..